MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3.090.412... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.06.23. Пүрэв. №127 (4497) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

МОНГОЛ АРДЫН НАМ ХАНДИВЫН ДАНС

"ХААН БАНК" 5115028001 тоот данс

**Иргэн та хандив өргөхдөө**
Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу:
50.1.1 Иргэн гурван сая төгрөг хүртэл /регистерийн дугаар/
50.1.2 Хуулийн этгээд арван сая төгрөг хүртэл /регистерийн дугаар/

**Сонгуулийн тухай хуулийн 40.3-д:**
..."Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийн банкинд нээлгэсэн, сонгуулийн зардлын дансанд энэ хуульд заасан журмын дагуу төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулна" гэсэн, заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дансыг нээсэн тул намын гишүүд, дэмжигчид, дэмжигч байгууллага, иргэд та бүхнийг хандив өргөхийг хүсье.

Дугаарын 60 мөр

## 30 саяын хохирлыг хэн төлөх вэ

Н.БАТЗАЯА

Хоёр өдрийн турш үргэлжлэн орсон бороены улмаас нийслэлийн зарим гудамж, талбай, айл өрхүүд усанд автлаа. Жилийн дөрвөн улирал ээлжлэх манай оронд зөвхөн өчигдөр үер бууж байгаа нь энэ биш. Жил бүрийн зун үерийн амад буусан айлууд усанд автаж, амь насаараа хохирсон "гашуун" сургамж бидэнд бий. Тэгвэл энэ удаад ч иргэдийн хариуцлагагүй байдал дахин давтагдаж хэд хэдэн айл үер автлаа. Тухайлбал, Баянзүрх дүүргийн 8, 12, 17, 21 дүгээр хорооны 100 гаруй айл усанд автаж, Рашаантын 7-12 дугаар гудамж үерийн гамшигт нэрвэгдэж, Онцгой байдлын албанаас 40 хүн, дүүргийн албадаас 34 хүн, таван механизм, есөн автомашин, гурван мотопомптойгоор шуурхай арга хэмжээ авч ажиллажээ.

Төгсгөл нь III нүүрт

Танилц:

## МАН, АН-ЫН ИРЭХ ДӨРВӨН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Б.ӨНӨРТОГТОХ

Монголчууд Үндсэн хуулиар олгогдсон төрийн эрх барих эрхээ эдлэхэд зургаахан хоногийн хугацаа үлдээд байна. Тодруулбал, УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгчдээ сонгох хугацаа энэ сарын 29-нд тохиож буй юм. Монгол түмэн энэ өдөр ирэх дөрвөн жилд хэн гэгч улс төрийн хүчин, улстөрчид итгэх вэ гэдгээ шийдэх түүхэн хариуцлагатай цаг мөч тохиож буй учраас "ММ" энэ удаагийн дугаартаа иргэдийн мэдлэгт нэмэр болох үүднээс намуудын мөрийн хөтөлбөрийг тоймлов. Мэдээж ардчилсан сонгууль явуулж эхэлсэн 25 жилийн хугацаанд улс төрийн хоёр томоохон хүчин болох МАН, эсвэл АН олонхийг бүрдүүлж төрийн эрхийг барьж ирсэн бөгөөд энэ удаад ч сонгогт энэхүү жишгээс хол зөрөхгүй. Тэр дундаа МАН, АН гэсэн хоёр том улс төрийн хүчинд иргэдийн дийлэнх нь хуваагдсан учраас хоёр улс төрийн хүчний аль нэг нь төрийн эрх барьж, Засгийн газар, УИХ-ыг бүрдүүлэх учиртай билээ. Тэр ч утгаараа энэ удаагийн дугаарт хоёр том намын мөрийн хөтөлбөрийг тоймлов. Мөрийн хөтөлбөр гэдэг бүх талын асуудлыг тусгах учиртай.

Үргэлжлэл нь III нүүрт

ДОТОР НҮҮРТ

БАРИЛГЫН ОСЛЫН УЛМААС ЗУРГААН ХҮН БЭРТЭЖ, НЭГ ХҮН АМИА АЛДСАН 7

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



## Д.БАТ-ЭРДЭНЭ: НЭР ДЭВШИГЧИД ХУУЛЬ ЗӨРЧСӨН АСУУДЛЫГ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ШАЛГАЖ, ШҮҮХ ТОГТООНО

Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

## ИРГЭД "САЙН ХАШАА" ХӨТӨЛБӨРИЙГ ИХ ХҮЛЭЭЖ БАЙЖЭЭ

Б.ДАВАА

Нийслэл хотын утаа, хөрсний бохирдлыг гэр хорооллынхон л бий болгож байна гэх хатуухан шүүмжлэл хаа нэгтээ хэвлэлийн хуудаснаа бичигдсэн байх нь бий. Хотын хүн амын 65 орчим хувийг хамрах "G" хорооллынхон ч бурууд бүлтэлзэн, өөрсдөө хордох хэдий ч, хананаасаа цэвэр, халуун усаа авчихдаг дулаанхан байранд ая тухтай амьдрахыг тэрүүхэндээ хүсэмжлэх авч санхүүгийн боломж амьдралын төвшингөөс хамаараад тэр бүр саснаар болдоггүй байсан цаг саяхан. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд нийслэлийн удирдлагууд "Гэр хорооллын дахин төлөвлөлт" гэх нөр их ажлыг санаачлан хэрэгжүүлснй дунд зуу зуун айл яндангаасаа салж, "G" хорооллынхон төчнөөн тооны өрхөөр цөөрсөн билээ. Тэд ингээд зогссонгүй. Гэр хорооллын хамгийн их бохирдолттой цэгт амьдарч буй иргэдээ анхаарал хандуулж, Засгийн газраас "Сайн хашаа"-ны ээзнд ээл олгож, амьдрах орчноо сайжруулахад нь анхаарч эхэлсэн байдаг. Тэгвэл сантехникийн хамгийн сайн шийдэл хэмээн мэргэжилтнүүдэд ихээхэн үнэлэгдэж буй тус хөтөлбөрийн талаарх үнэн бодит мэдээллийг өгөхөөр Нийслэлийн ИТХ-ын дарга Д.Баттулга, Нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч, нийслэлийн нутаг дэвсгэрт "Сайн хашаа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаат зохион байгуулах, чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн дарга С.Очирбат, Сүхбаатар дүүргийн ИТХ-ын дарга Б.Ган-Эрдэнэ нар Сүхбаатар дүүргийн 16 дугаар хороо буюу бидний нэрлэж заншсанаар Бэлх орчмын гэр хорооллд амьдрах Д.Дэжидгүнчингийнд зочилсон юм.

Төгсгөл нь II нүүрт







**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1945.00 | 1960.00 | ФУНТ | 2739.00 | 2822.00 |
| ЕВРО | 2170.00 | 2222.00 | РУБЛЬ | 28.00 | 31.80 |
| ИЕН | 18.48 | 18.95 | ЮАНЬ | 294.30 | 297.80 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1948.00 | 1962.00 | ФУНТ | 2766.00 | 2821.00 |
| ЕВРО | 2178.00 | 2225.00 | РУБЛЬ | 28.90 | 30.90 |
| ИЕН | 18.53 | 18.98 | ЮАНЬ | 295.00 | 298.20 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

АЙЛЧЛАЛ

## Ерөнхийлөгч Ташкентыг зорилоо

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж энэ сарын 23-24-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотноо болох Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн ээлжит 16 дугаар хуралдааны өргөтгөсөн хуралдаанд оролцохоор өчигдөр эх орноосоо мордлоо. Хуралдааны үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын ээлжит гурав дахь дээд төвшний уулзалтад оролцож, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин, БНХАУ-ын дарга Си Зиньпин, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ерөнхийлөгч Ислам Каримов нартай тус тус хоёр талын уулзалт хийнэ. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төрийн тэргүүн нарын уулзалт нь гурван талт худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хамтын ажиллагааны ирээдүйтэй чиглэлүүдийг тодорхойлох, дээд төвшинд хүрсэн тохиролцоог ажил хэрэг болгоход чухал ач холбогдолтой. Уулзалтын үеэр гурван талт хамтын ажиллагааны зарим баримт бичигт гарын үсэг зурахаар төлөвлөж байгаа ажээ.

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

## Иргэд “САЙН ХАШАА” хөтөлбөрийг их хүлээж байжээ



Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

“Сайн хашаа” хөтөлбөр хэрэгжихийг чих тавин хүлээж буй өрхийн нэгээхэн төлөөлөл нь тэднийх. Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны “Ойчид -1” гэх гудамжинд оршин суух энэ айлын эзэгтэйг Д.Шагдардаш гэдэг. Тэднийх 2000 оноос тэнд суурьшсан гэнэ. Тэд ч холбогдох албаныхнаас хэрэгтэй гэсэн бүхий л мэдээллээ авч байлаа. Нийслэлийн ИТХ-ын дарга Д.Баттулга “Гэр хорооллын дахин төлөвлөлт”-ийг хэрэгжүүлээд гурван жилийн нүүрийг үзэж байна. Харин өнөөдрийн энэ өнцгөөс харахад, иргэдийн оролцоо дутмаг байгаа нь анзаарагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, иргэд компанитай газраа орон сууцаар солино гэсэн гэрээ байгуулахаас өөр оролцоогүй байсан. Иргэдийн оролцоог дээшлүүлж байж л гэр хороололд жинхэнэ том бүтээн байгуулалтыг хийх юм байна гэдгийг ойлгосон хэрэг. Энэ утгаараа Засгийн газарт асуудал тавьж, Засгийн газар “Сайн хашаа” хөтөлбөрийг баталсан. “Сайн хашаа” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын дэд бүтцийн асуудалд зориулж нэг айлд 15 сая хүртэлх төгрөгийг зээлээр өгөхөөр болсон. Үүний 50 хувийг улсын болон хотын төсвөөс хариуцаж, үлдсэн 50 хувийг тухайн айл 20 жилийн хугацаанд төлөхөөр зохицуулсан юм. Зээл авсан айл өрхийн хувьд 15 сая төгрөг авсан бол 7.5 саяыг, 10 сая төгрөг авсан бол таван саяыг л буцааж төлнө гэсэн үг. Ингэж төлөхдөө мөн эхний хоёр жил ямар ч төлбөр төлөхгүй учраас санхүүгийн аливаа дарамтад орохгүй гэж ойлгож байгаа” хэмээн тайлбарлалаа. Түүнчлэн, иргэд тус хөтөлбөрт хамрагдсанаар бизнесийн маш том орон зай бий болж байгааг сануулж байсныг энд тэмдэглэх хэрэгтэй болов уу.

...Нэг сумаар хоёр биш бүр “гурван туулай” буудах бизнесийн супер санааг дурьдаж байв. Түүний хэлж буйгаар “Сайн хашаа” хөтөлбөрт дангаараа бус нөхөрлөл болж, 100, 200-аараа нэгдэж, иргэд өөрсдөө барилгын салбарт хүч үзэн, ажил орлоготой болохоос гадна, хөрсний бохирдолгүй дулаан байрандаа ая тухтай амьдран, тодорхой хэмжээний мөнгөн хадгаламжтай болох гурван том боломж бий аж...



Нэг сумаар хоёр биш бүр “гурван туулай” буудах бизнесийн супер санааг тэрбээр дурьдаж байв. Түүний хэлж буйгаар “Сайн хашаа” хөтөлбөрт дангаараа бус, 100, 200-аараа нэгдэж нөхөрлөл болж иргэд өөрсдөө барилгын салбарт хүч үзэн, ажил орлоготой болохоос гадна, хөрсний бохирдолгүй дулаан байрандаа ая тухтай амьдран, тодорхой хэмжээний мөнгөн хадгаламжтай болох гурван том боломж бий аж. Д.Баттулга хэлэхдээ, “Хөтөлбөрт 200 айл нэгдэх гэж бодъё. 200 айл хоорондоо тохироод нэгдвэл гурван тэрбум төгрөгтэй болно. Түүний 1.5 тэрбумыг төр даана. Нэг ёсондоо дэд бүтцээ шинэчлэх зорилгоор гурван тэрбум төгрөгтэй болчихоод цахилгаан, дулаан, бохир, цэвэр усныхаа асуудлыг бүрэн шийдчих боломжтой болно гэсэн үг. Нөгөөтэйгүүр 200 айл нэгдсэнээр тэдний газар дунджаар 6-7 га талбайг эзэлнэ. Улаанбаатар хотод ийм том хэмжээний сул газар гэж одоо байхгүй болсон. Дэд бүтцээ татчихсан 6-7 га газрыг тэгвэл банкинд барьцаалаад зээл аваад нэлээд хэдэн тэрбум төгрөг болно. Тэр мөнгөөрөө иргэд хашааны газар дээрээ орон сууц барих боломжтой юм. Ямар компаниар бариулахаа өөрсдөө сонгож, өөрсдөө хяналт тавиад явна. Ингээд 200 айл орон сууцандаа орсны дараа цаана нь мэдээж сул байрууд үлдэж таарна. Харин тэр илүү гарсан байруудыг түрээсийн орон сууц болгож нийслэлээс худалдаж авч болно. Үгүй гэвэл орон сууцны эзэд өөрсдөө Засгийн газрын таван хувийн зээлд хамруулаад өгчихөж болно шүү дээ. Ингээд борлуулсан мөнгөнийхөө нэг хэсгээр эргээд банкны зээлээ төлчихнө. Харин үлдсэн хэсэг нь газрын эзэн 200 айл өрхийн хуримтлал болж үлдэх юм.

Нэг ёсондоо иргэдэд бизнес санал болгож байна” гэлээ. Тус айлын эзэгтэй Д.Шагдардаш, мөн хорооны иргэн Ц.Байгальмаа нар түүний яриаг анхааралтай сонсч, сонирхсон асуултаа ч асууж, дэлгэрэнгүй мэдээлэл авлаа. Найрсаг зантай, ажилч хичээнгүй гэдэг нь хэнд ч тод харагдах Д.Шагдардаш эгч хөтөлбөрийн талаар “Хувь хүмүүс төвийн дулааны шугамд холбож өгье гэдэг л юм. Гэхдээ үнэ өртөгийг нь дийлдэггүй. Харин “Сайн хашаа” хөтөлбөр хэрэгжиж, мөрөөдөл минь биелэх нь хэмээн баярлаж сууна. Улс өдөр ирэх тусам хөгжиж байгаа ч, байранд орох өдий байна даа гэж боддог байлаа. Гудамжныхаа айл өрхүүдтэй зөвлөлдөж, дэд бүтцийн шугамаа татаад, мөнгө үлдвэл байшингаа дулаалчихдаг юм билүү гэж бодож байна. Гэхдээ хараахан шийдээгүй. Өрхүүдтэйгээ ярилцана. Сантехникийн шугам нь ердөө гурван буудлын цаана бий. Өмчийн хашааны газартай л бол хэн ч хамрагдаж болох юм билээ.

Үүнээс гадна авсан зээлийнхээ 50 хувийг 20 жилийн хугацаанд төлнө. Сантехникийн асуудлаа шийдчихвэл, ээлээ дор нь дарна шүү дээ. Долоо, найман сая төгрөгөөр сайхан амьдрах боломжтой болох нь байна шүү дээ. Хөгшин болохоор нүүрс түлээндээ явах, усаа зөөх жаахан хүндрэлтэй байдаг юм” гэж хүүчиллаа. Дашрамд дурьдахад, инженерийн хамгийн сайн шийдэл болох уг хөтөлбөрт хамрагдах иргэд хүсэлтээ аймаг, нийслэлийн хот байгуулалт болон орон сууцны асуудал хариуцсан байгууллагад гаргах юм байна.

Улмаар сайжруулсан гэр хорооллын бүсэд хамаарах тухай тодорхойлолт авч хөтөлбөрт оролцох шаардлага хангасан компаниас сонголтоо хийж, банкинд хүсэлтээ тавих замаар банк зээлийг иргэний сонгосон компанид шилжүүлэх ажээ. Энэ бол түүхэндээ анх удаа хийгдэх гэж буй ажил юм. Мэргэжлийн байгууллагаар тооцоо хийлгэхэд тухайн айл бохир хийхэд 2.4, цэвэр бохир усны хангамж хүргэхэд 3.5, халаалтын асуудлыг шийдэхэд дөрвөн сая төгрөг буюу нийт 9.9 сая төгрөг хэрэгтэй гэжээ. Мөн тухайн нутаг дэвсгэрт амьдарч буй иргэдийн дийлэнх нь орлого багатай байгаа. Тиймээс эхний хоёр жил төлбөр авахгүй, түүний дараа жилээс эргэн төлөлт нь сард 100 мянган төгрөгөөс хэтрэхгүйгээр төлдөг байхаар зохицуулах аж. Хамгийн гол нь өөрийн өмчлөлийн хашаандаа, дассан сурсан газартаа амьдрахдаа гал түлж, гадаа бие засахгүй болох нь.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## ЖДҮ-ийг дэмжих төслийг АНУ-тай хамтарч хэрэгжүүлэх нь

Жижиг дунд бизнес рүү чиглэсэн шинэ төслийн нээлт өчигдөр боллоо. АНУ-ын ОУ-ын хөгжлийн агентлаг (USAID), “Хөгжлийн шийдэл” ТББ хамтран REACH төслийг хэрэгжүүлж эхэллээ. Төслийн нээлтэд АНУ, Япон, Солонгос, ЕХ-ны Монгол дахь ЭСЯ-ны ажилтнууд, олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчид болон АҮЯ, Зээлийн батлан даалтын сангийн мэргэжилтнүүд оролцов. Төслийг нээж АНУ-ын элчин сайд Женифер Зимдал Галт үг хэлэв. Тэрбээр, жижиг дунд бизнес эрхлэгчид Монголын ДНБ-ий 20 хувийг бүрдүүлдэг. Гэвч тэдэнд хангалттай санхүүгийн эх үүсвэр байдаггүй. Тэдний 75 хувь нь зээл авах хүсэлтэй байдаг тул энэ эрэлт хэрэгцээг хангахад REACH төслийн баг дэмжлэг үзүүлнэ гэв. Төслийн баг зээл авах хүсэлтэй жижиг дунд бизнес эрхлэгчдэд зөвлөх болон зуучийн үйлчилгээ үзүүлэх юм.

Зөвлөх үйлчилгээ нь жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох зорилготой. Бизнес төлөвлөгөө хэрхэн бичих, бүртгэл тооцоололоо зөв хөтлөх, зээлийн боловсрол гэсэн гурван үндсэн сэдвээр тогтмол сургалт, мэдээллээ өгөх уулзалтууд зохион байгуулж, ном, гарын авлага хэвлүүлнэ. Төслийн баг Зээлийн батлан даалтын сан, Аж үйлдвэрийн яам болон арилжааны банкуудтай хамтран ажиллах аж. АҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын Ш.Гэрэлцэцэг 2012-2016 онд жижиг дунд үйлдвэрлэлийн 1500 төсөлд 241 тэрбум төгрөгийн зээл олгосныг онцлов. Үр дүнд нь олон үйлдвэр ашиглалтад орж, нийт 13 мянган ажлын байр бий болгожээ. Одоо энэ салбарт 7000 орчим хүн ажиллаж байгаа юм. Мөн Хөгжлийн банкнаас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 200 тэрбум төгрөгийн зээл олгож байгааг дуулгав. Үүний 50 тэрбум төгрөгийг Сум хөгжүүлэх сангуудаар дамжуулан олгоод байгаа аж.

## УИХ-ын чуулган хуралдана



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ-ын дарга З.Энхболд өнгөрсөн тавдугаар сарын 23-нд УИХ-ын хаврын чуулганы түр завсарлуулахаар гаргасан захирамжид “Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы 2016 оны зургаадугаар сарын 23-ны өдрийг хүртэл түр завсарлуулж байна” гэж мэдэгдсэн.Захирамж ёсоор УИХ-ын чуулганы түр завсарлага дуусгавар болж, өнөөдөр УИХ байнгын хороодын хуралдаанаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлнэ. Тодруулбал, 09.00 цагт Хууль зүйн байнгын хорооны хуралдаан “Их эзэн Чингис хаан танхим”-д, .Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаан “Жанжин Д.Сүхбаатар танхим”-д, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаан “В” танхимд тус тус хуралдах юм байна.

## СЕХ Н.Бүрэгдааг нэр дэвшигчийн жагсаалтаас хаслаа

Х.САРНАЙ

УИХ-ын сонгуулийн 11 дүгээр тойрог Говь-Алтай аймагт МАХН-аас нэр дэвшсэн Н.Бүрэгдааг СЕХ хуралдаж, нэр дэвшигчийн жагсаалтаас хасчээ. Сонгуулийн жил эхэлснээс хойш санал хураах дуустал аливаа этгээд сонгогчдын саналыг татах зорилгоор эд зүйл тараах, худалдах, аливаа үйлчилгээг төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх, нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, бооцоот тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх, сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглодог Сонгуулийн тухай хуулийн 70.1 дэх заалт болон шүүхийн шийдвэрийг үндэслэжээ. Дашрамд дурьдахад, саналын хуудас хэвлэгдсэний дараа энэхүү шийдвэрийг гаргасан тул Н.Бүрэгдаад өгсөн саналын хуудсыг хүчингүйд тооцох юм байна.


mminfo.mn
Шударга, Шуурхай, Өнгөц мэдээлэл

МОНГОЛЫН МЭДЭЭ

17 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Тоймч: Х.БАТСАЙХАН 88094039

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 210, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

## ҮЗЭЛ БОДОЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# МАН, АН-ЫН ИРЭХ ДӨРВӨН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

...МАН-ынхан оюутнуудын цагаар ажиллах боломжийг хангахаас гадна, төрийн өмчийн сургуулиуд төрийнхөө өмчит л байх эрхзүйн орчныг бүрдүүлэх амлалт өгсөн байна. Үүнээс гадна АН-ынхан залуусыг ажлын байраар хангах төсөл хэрэгжүүлэх гэнэ. Гэртээ хүүхдээ асарч байгаа ийм ээжүүдийн нийгмийн асуудлыг шийдэх гарцыг МАН мөрийн хөтөлбөртөө багтаасан аж...

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Эдийн засаг, нийгмийн бодлого, халамж, мөнгө санхүү, уул уурхай гээд өнөөгийн нийгэмд яригдаж буй сэдэв бүхнийг хамарч байж л мөрийн хөтөлбөр болно. Хэдийгээр улс төрийн намуудын эрх барих хугацаа дөрвөн жилээр хэмжигддэг ч дөрвөн жилийн хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлаа нэгбүрчлэн бичиж, иргэддээ тайлагнаж байж л мөрийн хөтөлбөр биелэлээ олох юм. Монгол Улс өнгөрсөн хаврын УИХ-ын чуулганаар бүх нам эвслийн төлөөллөөс оролцсон Хөгжлийн хөтөлбөрийг баталсан юм. Тэгвэл улс төрийн намууд энэхүү хөтөлбөрт уялдуулан мөрийн хөтөлбөрөө боловсруулах учиртай. Тэр ч утгаараа хэн нь илүү мөнгөний амлалт өгсөн бэ гэхээс илүүтэй хэн нь амьдралд илүү нийцтэй бодлого боловсруулах вэ гэдэг л чухал. МАН-ын мөрийн хөтөлбөрийг ерөнхийд нь ажиглахад зүүний чиглэлийн нам гэдэг утгаараа нийгмийн халамжийг илүүтэй анхаарчээ. 107 заалт бүхий мөрийн хөтөлбөр товч бөгөөд тодорхой, мөнгө өгнө, цалин тэтгэвэр нэмнэ гэсэн утга агуулгатай. Харин АН-ын хувьд өнгөрсөн 2012 оны сонгуулийн өмнөхөн бүх аймаг, сум дүүргээр явж судалгаа хийсэн “Монгол хүн-2020” хөтөлбөрөө барьж орж буй. Найман жилээр төлөвлөсөн мөрийн хөтөлбөрөө өнөө жилийн сонгуулиар барьж орохдоо өмнөх хийсэн ажлаа үргэлжлүүлэх, эсвэл хийж эхлэх ажлаа төлөвлөсөн хэт нүсэр болжээ. АН-ын мөрийн хөтөлбөр нь таван бүлэг, 15 салбараар хуваасан 418 заалт бүхий мөрийн хөтөлбөр болжээ. Том, том бодлогын ерөнхий уриа шинжтэй уриалга, амлалт гэхээс илүү уншигчдын амьдралд хамгийн ойрхон цалин, тэтгэвэр, нийгмийн халамж, оюутны төлбөр, малчдын урамшуулал, эхчүүдийн тэтгэмж гэсэн цөөхөн хэдэн заалтыг л энэ удаад тоймлохыг чухалчилсан юм.

### МАНАН-ын мөнгөний амлалт

МАН-ын хувьд жил бүр цалин тэтгэврийг үе шаттай нэмэгдүүлнэ хэмээн мөрийн хөтөлбөрт тусгажээ. Хатуухан хэлэхэд өмнөх л үе шаттай нэмнэ гэсэн ерөнхий амлалтаас хэтрэхгүй. Инфляци, эдийн засгийн нөхцөл боломжийг тооцохгүйгээр жил бүр үе шаттай нэмэх боломж тэр болгон байхгүй. Тэгвэл АН-ын хувьд инфляцийн төвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ гэсэн заалт оруулсан аж. Гэвч Монгол Улсын эдийн засаг жил ирэх тусам муудаж, гадаад хөрөнгө оруулалт багасч буй энэ үед цалин нэмэх тухай яриа бараг л мөрөөдөл төдий байгаа нь худлаа биш. Цаашид эдийн засгаа эрүүлжүүлж, уул уурхайгаас хэт хамааралтай байдлаас гарч чадахгүй л бол хоёр намын цалин нэмэх тухай амлалт хоёулаа л цаасан дээрх амлалт болоод өнгөрөх нь тодорхой байгаа юм. Тэгвэл тэтгэвэр нэмэх тухай асуудлаар МАН-ын бүлэг жил бүр нэмэгдүүлж, зээлийн хүүг бууруулах мөн ахмадууддаа “Насны хишиг” тэтгэвэр олгох эрхзүйн орчин бүрдүүлж, тэтгэврийн зөрүүг арилгана хэмээн амалжээ. Харин АН-ын тухайд тэтгэврийн шинэчлэлийг эрчимжүүлж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэмэх тухай болон хувийн тэтгэврийн тогтолцоог бий болгоно хэмээжээ. Мөн АН-ынхан өнгөрсөн дөрвөн жилд “Хамтын тэтгэврийн тухай хуулийн төслийг санаачилж батлуулсан бөгөөд энэ нь нас барсан нэгнийхээ тэтгэврийг үлдэж хоцорсон хөгшин нь авах боломжтой хуулийн төсөл юм. Тэдэн төгрөгөөр нэмнэ гэсэн амлалт өгч болохгүй учраас хоёр намын тухайд адилхан ерөнхий зүйлийг амласан аж. Иргэдийнхээ өрхийн орлогыг нэмэгдүүлэх тухай амлалтад МАН орлого багатай иргэдээ дэмжих, орлогыг хоёр дахин нэмэгдүүлнэ хэмээн тусгасан бол АН-ынхан мөн л өрхийн орлогыг хоёр дахин нэмэгдүүлнэ хэмээн заажээ. Үндэсний статистикийн газраас өгч буй мэдээллээр дундаж амьдралтай иргэдийн өрхийн орлого 300-500 мянгад хэлбэлзэж буй. Тэгвэл хоёр намын өгсөн амлалтаар энэ орлого нэг сая хүртэл төгрөг болох нь ээ. Дараагийн мөнгөтэй холбоотой амлалт бол хүүхдэд олгож буй халамж. Анх Л.Гүндалай гишүүний санаачилж байсан “Хүүхэд бүрт-10000” амлалт өдгөө намуудын хамгийн гол санал авах амлалт болж хувирсан. Жил жилийн сонгуулиар энэ амлалт бага зэрэг өөрчлөгддөг ч өнөө жил мөн л амлалтын нэг гол концепц болж оржээ. МАН хүүхдийн мөнгийг хэвийн олгохоо амласан бол, АН ч мөн адилхан хүүхдийн мөнгийг олгох эрхзүйн орчныг өөрчлөхгүй хэмээн тусгажээ. Цэцэрлэгийн хүртээмжийн тухайд МАН "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөр хэрэгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ" гэж заасан аж. Харин АН-ын тухайд цэцэрлэгийн асуудлыг илүү бодитой буюу хүүхэд харах үйлчилгээг үргэлжлүүлэх, гэр цэцэрлэг, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, гэрийн сургалт өргөтгөх, мэргэжлийн ажиллах хүчнийг улс төрөөс хараат байлгах, сургууль цэцэрлэгийн байр нэмэх зэрэг заалтуудыг тусгажээ.

### Оюутан, малчны талаар АН-ын бодлого илүүтэй таалагдаж байна

Харин оюутнуудад чиглэсэн бодлогын тухайд АН-ынхан өнөөдөр хэрэгжүүлж буй бодлогоо үргэлжлүүлэх гэнэ. Тодруулбал, сонгуулийн өмнөхөн хэрэгжиж эхэлсэн “Сайн оюутан” хөтөлбөр буюу оюутны сургалтын төлбөрийн зээл хэрэгжүүлэх бол МАН-ын мөрийн хөтөлбөрт энэхүү оюутны зээлийг “Боловсролын зээлийн сан” байгуулж шийднэ хэмээн оруулжээ. Мөн АН-ынхан дэлхийн шилдэг 100 их дээд сургуульд оюутан суралцуулж буй бодлогоо үргэлжлүүлж тоог нь нэмэхээ амлажээ. Мөн Японы 1000 инженер хөтөлбөрийг үргэлжлүүлэхээ амласан байна. Харин МАН-ынхан оюутнуудын цагаар ажиллах боломжийг хангахаас гадна, төрийн өмчийн сургуулиуд төрийнхөө өмчит л байх эрхзүйн орчныг бүрдүүлэх амлалт өгсөн байна. Үүнээс гадна АН-ынхан залуусыг ажлын байраар хангах төсөл хэрэгжүүлэх гэнэ. Гэртээ хүүхдээ асарч байгаа ийм ээжүүдийн нийгмийн асуудлыг шийдэх гарцыг МАН мөрийн хөтөлбөртөө багтаасан аж. Тухайлбал, хүүхэд төрүүлсэн ээжүүдэд даатгуулсан хэлбэрээс нь үл хамааран хөдөлмөрийн хөлснөөс адил хувиар тооцон тэтгэмж олгох юм байна. 70 хүртэл хувийн тэтгэмж авдаг одоогийн тогтолцоог өөрчилж цалингаа бүтэн, тэтгэмжээ 100 хувь авах боломж олгох юм. Түүнчлэн хүүхдээ гурван нас хүртэл асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа тасрахгүй байх боломж бүрдүүлэх гэнэ. Ингэснээр ажил хийнэ гэлгүйгээр хүүхдээ харангаа сар бүр гар дээрээ цалингаа авч болох билээ. Харин АН хүүхэд хардаг, удаан хугацаагаар ажил эрхлээгүй эмэгтэйчүүд, ганц бие эцэг, эхчүүдийгтөрийнбайгууллага,томоохон аж ажуйн нэгжүүдээс боломжит ажил үйлчилгээг туслан гүйцэтгүүлэх, нийгмийн идэвхтэй амьдралд татан оруулах, ажлын уян хатан нөхцөл бүхий “Цагийн ажил” хөтөлбөр, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ” төслийг тус тус хэрэгжүүлэхээр болжээ. Халамжийн тухайд АН тодорхой заалт тусгаагүй бөгөөд өнөөх л шинэчлэл гэсэн ерөнхий зүйл заалтаар ам хаажээ. Гэтэл өнөөдрийн нийгэмд эхчүүдийн асуудал хамгийн чухалд тооцогдож буй бөгөөд хүн амаа өсгөх гэвэл эхчүүдийнхээ халамжийг нэмэх, бодлогын дэмжлэг үзүүлэх шаардлага юу юунаас чухал байгаа юм. Малчдын тухайд гэвэл Ардын намынхан малчдын хүүхдийг зургаан настайд нь биш 7, 8 настайд нь сургуульд оруулж болохоор мөрийн хөтөлбөртөө тусгасан байгаа. Мөн малчдын тэтгэврийн насыг таван жилээр наашлуулах гэх мэтчилэн малчдад тулгардаг олон асуудлыг мөрийн хөтөлбөртөө оруулжээ. Мөн “Мах, сүүний анхдугаар аян” өрнүүлэхийн зэрэгцээ “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, фермерийн аж ахуйг зохистой хослуулснаармах,махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх саналыг мөрийн хөтөлбөртөө тусгажээ. Харин АН-ын тухайд хөдөө аж ахуйн чиглэлээр тун ч дэлгэрэнгүй мөрийн хөтөлбөр тусгажээ. Тодруулбал, “Сайн малчин” хөтөлбөрөө үргэлжлүүлж малчдын амьжиргааны төвшинг баталгаажуулж, үйлдвэрлэл явуулахад дэмжлэг үзүүлэх, мөн орон нутагтаа амьдрах боломжийг хангах, шилмэл үүлдэрийн малыг өсгөж үржүүлэх, малын удмын сангийн цогцолбор байгуулах, малын эмийн болон био бэлдмэлийн үйлдвэр байгуулах зэрэг заалт тусгажээ.

Дугаарын 60 мөр

## 30 саяын хохирлыг хэн төлөх вэ

**Төгсгөл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэ мэтчилэн иргэд өөрсдийн ухамсаргүй үйлдлээс болж гэр орноо усанд автуулж, эд хөрөнгөөрөө хохирдог түүх жил бүр л давтагдах болж. Цаашдаа ч тохиолдохгүй гэх баталгаагүй. Нэг үгээр хэлбэл, үерийн даланд ойрхон буусан нь өөрсдийнх нь буруу гээд хэлчихэд нэг их буруудахгүй биз. Өнөөгийн нийгэмд миний эрх бусдын эрхээр хязгаарлагдах учиртай. Гэтэл ухамсаргүй, хариуцлагагүй, аминчхан үзэлтэй ганц хүний уршгаар хэдхэн хоногийн өмнө ашиглалтад орсон автозам гэмтсэн жишээ ч байна.

Энд нэгэн түүхийг эргэн сануулъя. Дамбадаржаагийн уулзвараас Шаргаморьтын төмөрбетон гүүр-Хандгайт чиглэлийн 16.35 км иж бүрэн автозам энэ сарын 06-нд бүрэн ашиглалтад орж, нийслэлчүүд зурайсан шинэхэн замаар зуслангаа зорьдог болсон. Гэтэл хэдэн өдөр үргэлжлэх орсон борооны улмаас замын тодорхой хэсэгт буюу доод Салхитын ам орчимд ус хуримтлагдан тээврийн хэрэгсэл зорчиход хүндрэлтэй нөхцөл байдал үүсч, замд эвдрэл гарчээ. Хамгийн хачирхалтай нь, ашиглалтад ороод 16 хоножбуй уг замын эвдрэл ганц хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой байсан гээд бод доо. Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо доод Салхитын 1-16 тоотод оршин суугч М гэгч үерийн ус зайлуулах хөндлөн хоолойг хааж, битүүлсний улмаас зам дээр нэлээд хэмжээний эвдрэл гарч, хашаа руу нь ус орсон ажээ. Ганцхан аминчхан үзэл, хариуцлагагүй байдлаас болж Салхитын чиглэлийн замын хөдөлгөөн зогсч, бүхэл бүтэн бүтээн байгуулалт сүйдчихлээ. 30 сая төгрөгөөр улс хохиров. Өмнө нь ийм тохиолдол гарсан. Өнгөрсөн тавдугаар сард шар усны үер болоход мөн л ийм байдал үүссэн байх юм.

Тухайн үед нийслэлийн Авто замын газраас иргэн М-тэй уулзаж, шугам хоолойг битүүлэхгүй байхыг удаа дараа хүсч, хашаан дотор нь ус зайлуулах хоолой татаж өгье гэсэн ч зөвшөөрөөгүй байна. Энэ мэтээр нэг иргэний буруутай үйлдлээс нэлээд хэдэн хүн хохирч, улсын төсвөөр хийсэн дэд бүтцийн бүтээн байгуулалт сүйдсээр байгаа юм. Ус цаг уурын хүрээлэнгээс ирэх долдугаар сард аадар бороо орно гэдгийг ард иргэдэд анхааруулж буй. Тиймээс үерийн аманд буусан айлууд өөрсдийнхөө болоод улс орноо боддог л бол ухамсартай байж, нүүхийг хүсье. Эцэст нь хэлэхэд, төр засгаа шүүмжлэн суухын оронд өөрсдөө иргэний үүргээ ухамсарлан хариуцлагатай байчих л даа.

MMINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл



# УЛС ТӨР

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗЛАА



Н.БАТЗАЯА

УИХ-ын дарга, Ардчилсан намын дарга, УИХ-ын сонгуулийн 70 дугаар тойрогт Ардчилсан намаас нэр дэвшигч З.Энхболд, УИХ-ын гишүүн, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, УИХ-ын гишүүн С.Одонтуяа болон Баянгол дүүрэгт ИТХ-ын сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигчид өчигдөр Баянгол дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөлтэй уулзлаа. Уулзалтын үеэр мөрийн хөтөлбөр болон тус дүүрэгт нэр дэвшигчдээ танилцуулсан юм. Энэхүү уулзалтыг нээж, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ "Манай улсын хэмжээнд 140 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг. Түүнээс Баянгол дүүрэгт найман мянга гаруй иргэн амьдарч байна.

Монгол Улсын үнэт баялаг иргэн таны хөгжлийн төлөө ажиллах үүрэг хариуцлага хүлээсэн Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам байгуулагдсан өдрөөсөө эхлэн хүн амаа хөгжүүлж, тэдний эрх ашгийг хамгаалах, амьдралын чанарыг сайжруулах цогц бодлогыг дэвшүүлж, дэвшүүлсэн зорилтоо амьдралд дэс дараатай хэрэгжүүлж ирсэн. Хууль зүйт нийгэмд хуулиар хамгаалагдаагүй иргэний эрх нь ямагт зөрчигдөж, тэр хэмээр амьдралын төвшин доройтон буурч байдаг нь олон улсын туулсан амьдралын түүхээс харагддаг. Өнөөдөр бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ нийгмийн харилцаанд адил тэгш эрхтэй оролцуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдэнд тулгарч байгаа саад бэрхшээлийг багасгахад хүн хүчин чадлаа нэмэгдүүлэхийн тулд энэхүү уулзалтыг зохион байгууллаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх хамгааллыг дээшлүүлэх, нийгмийн харилцаанд оролцох боломж,нөхцөлийгсайжруулах чиглэлээр хийх ажил олон байна. Монгол Улсын Засгийн газар хүн ам, бүлгүүдийн асуудлыг хариуцсан бүтэц бий болгож, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан шинэ бүтэц, хэлстийг бий болгосон. Өмнө нь төр засгаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн баримтлах бодлого нь нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг нэгтгэн авч үздэг байсан. Харин одоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх оролцоо, хөгжлийн асуудлыг нэн тэргүүнд авч үзэх бодлогыг баримтлан ажиллаж ирлээ" гэсэн юм.

Мөн тэрбээр, манай улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй төрийн бодлогыг НҮБ-аас сайшаасан болохыг дурьдаад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалахад хийгдсэн эрхзүйн шинэчлэлийг онцоллоо. Өнгөрсөн дөрвөн жилд хууль эрхзүйн олон шинэчлэл хийгджээ. Тухайлбал, 2013 оны хоёрдугаар сард хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн конвенцийг хэрэгжүүлэх 2013-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталжээ. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгмийн хамгааллын тусламжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хэд хэдэн ажлыг зохион байгуулсан байна. Энэ мэтчилэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн эрхзүйн болоод хөрөнгө оруулалтын томоохон ажлууд хийгджээ. Уулзалтын үеэр иргэд УИХ-ын сонгуулийн 70 дугаар тойрогт Ардчилсан намааснэрдэвшигчС.Эрдэнийг дэмжиж буйгаа илэрхийлэн, цаашид хийж хэрэгжүүлэх ажлыг нь ч сануулж байсан юм. Энэ үеэр иргэдтэй уулзаж, тэдний санаа бодлыг сонслоо.

### Я.Авирмэд: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан хэлтэс ажиллаж эхэллээ

*/Баянгол дүүргийн нэгдүгээр хорооны иргэн/*

-Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой олон асуудал шийдэгдэн бодлогын хэмжээнд хэрэгжлээ. Монголын түүхэнд анх удаа Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудал хариуцсан хэлтэс ажиллаж эхэлсэн. Энэхүү хэлтэс болон бусад албаны хүмүүсийн хөдөлмөрийн хүчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо, хүсэлд нийцсэн хууль батлагдсанд баяртай байна. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, бидний эрх ашгийг хамгаалсан олон ажил хийгдлээ. Тухайлбал, Ази номхон далайн бүс дэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Инчоны стратеги батлагдсан. Уг стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлагдаж байгаа. Энэ мэтчилэн бодлогын хэмжээний ажлууд эрчимтэй хийгдсэнд баяртай байна. Цаашид энэ эрч хүчээ битгий алдаарай гэж хэлмээр байна. Хуулийн бичиг баримт гаргах нэг ажил. Үүнийг амьдрал дээр буулгаж, айлын гэрийн хаалгаар оруулах, хүнд хүргэх ажил үлдсэн. Энэ ажил хамгийн чухал. Тиймээс энэхүү чухал ажлыг дараагийн дөрвөн жилд хэрэгжүүлээсэй.



### Г.Болдсайхан:Дэд бүтцийн төлөвлөгөөг шалгадаг тогтолцоонд шилжихийн төлөө ажиллах хэрэгтэй

*/Баянгол дүүргийн гуравдугаар хорооны иргэн/*

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан бүтэц бий боллоо. Ер нь өнгөрсөн дөрвөн жилд хууль эрх зүйн хүрээнд суурь бүтэц бий болсон гэж би дүгнэж байна. Цаашид хуульд заасан Засгийн газрын дэргэдэх агентлаг, Ерөнхий сайдын дэргэдэх үндэсний зөвлөл байгуулах хэрэгтэй. Мөн орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан Засаг даргын дэргэдэх тодорхой бүтцүүдийг бий болгох нь чухал. Түүнчлэн санаатай болон санаандгүй байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зөрчигддөг асуудлыг таслан зогсоох чиглэлээр ажил хийх шаардлагатай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд нэг асуудал байдаг нь дэд бүтэц. Дэд бүтэцтэй холбоотой асуудлууд тодорхой хэмжээнд шийдэгдлээ. Ер нь хот төлөвлөлт хийхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг шийдсэн эсэх, зориулалтын зам талбай байгаа эсэхийг шалгаж авдаг тогтолцоонд шилжих хэрэгтэй юм. Эсвэл зам талбайн барилга барих зөвшөөрөл өгөх ажлын хэсэг болон барилга байгууламж хүлээж авах улсын комисст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл байх ёстой. Тэгэхээр энэ чиглэлд анхаарч ажиллах байх.

### Ц.Мөнхсаруул: Эрхзүйн орчин бүрдсэн

*/Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны ерөнхийлөгч/*

-2008 оны арванхоёрдугаар сарын 19-нд УИХ-аар Нэгдсэн үндэсний байгууллагаас эрхлэн гаргасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай конвенцийг баталсан. Дараа нь Инчоны стратеги батлагдаа. Сая хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай хууль батлагдсан. Эндээс манай улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчин бүрдсэн байгаа нь харагдана. Одоо энэ хуулиа хэрэгжүүлэх л хэрэгтэй. Би Японы нийслэл Токио хотод Ази номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ассоциацид суугаад ирсэн. Токиогийн ассоциациас би хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль эрхзүйн орчныг сайжруулах тухай тунхаг бичиг авчирлээ.Хөгжлийнбэрхшээлтэй иргэдийн маш олон байгууллага бий. Тэр байгууллагуудтай төр засаг хамтарч ажиллах хэрэгтэй. Төрийн бус байгууллага учраас эд нар юу хийж чаддаг юм гэсэн байдлаар ханддаг. Тиймээс дараагийн дөрвөн жилд энэ хандлагыг өөрчлөхийн тулд, төрийн бус байгууллагаа тоодог болгохын төлөө ажиллах хэрэгтэй.

ХӨНДӨХ СЭДЭВ

## АХМАДУУДЫН ТЭТГЭВРИЙГ НЭМЭХ БИШ БУУРУУЛАХ САНАЛ ГАРГАСАН АН

...Бодит байдлыг зарим тоон мэдээллийн хамт үзвэл 2015 оны хоёрдугаар сарын байдлаар арилжааны банкуудаар олгогдсон тэтгэврийн зээлийн үлдэгдэл 340.7 тэрбум төгрөгт хүрч гурван жилийн өмнөх үетэй харьцуулахад гурав дахин нэмэгдсэн бол зээлдэгчдийн тоо энэ хугацаанд 40 орчим хувиар нэмэгдэж өдгөө 190.000-д хүрсэн байна...

Г.ХАНХҮҮ

АН-ынхан хэзээнээсээ өнгөрсөн үе рүүгээ нулимж сурсан улс. Төдийгөөс өдий хүртэл хийж хэрэгжүүлж ирсэн бүхнийг үгүйсгэнэ. Байтлаа улс орондоо хийсэн бүтээсэнтэй ахмад буурлуудаа хүртэл ад үзнэ. Олон жилийн дараа засгийн эрх барих боломжтой болуутаа ахмадуудыг хамгийн их ад үзсэн. Өнгөрсөн хугацаан дахь үе үеийн Засгийн газрын бодлогод ахмадууд зүй ёсоор багтдаг, тэдэнд чиглэсэн бодлого явуулж ирсэн түүхтэй. Гэтэл АН засагласан дөрвөн жилд ахмадууд ад шоо үзэгдэх болов. Тэр бүү хэл, жил бүр инфляцийн төвшинтэй уялдуулан нэмж байх учиртай тэтгэвэр тэтгэмжийг нэмэх нь бүү хэл хасч танах тухай ч ярьж байлаа. Тийм ч учраас ахмадууд АН-д аль хэдийнэ "баяртай" гээд хэлчихсэн сураг дуулдана. Өнгөрсөнгүй өнөөдөр гэж үгүй. Тийм ч учраас үе үеийн Засгийн газрын үндсэн бодлогод ахмадуудыг нэн тэргүүнд авч үздэг байлаа. Харин "цэцэгнээс дэлбээлсэн" АН-ынхан ахмадуудын асуудлыг өнгөрсөн хугацаанд үндсэндээ хаясан учраас өнөөдөр амаа асуулгаж явна. Адаглаад Ардын намын зүгээс ахмадуудын тэтгэврийн зээлийн хүүг бууруулах санаачилгыг удаа дараа гаргаж, бүх тооцоо судалгааг нь танилцуулж байлаа. Гэсэн ч эрх баригч АН-ынханд энэ үнэхээр онц асуудал байгаагүй. Тийм ч учраас тэтгэврийн зээлийн хүүг бууруулах талаар ам ч нээж байсангүй.

Эх орноо эн зэрэгт хүргэх гэж, дор бүрнээ хичээн ажиллаж ирсэн ахмадууд өнөөдөр өрийн сүлжээнд орчихсон суугаа. Бодит байдлыг зарим тоон мэдээллийн хамт үзвэл 2015 оны хоёрдугаар сарын байдлаар арилжааны банкуудаар олгогдсон тэтгэврийн зээлийн үлдэгдэл 340.7 тэрбум төгрөгт хүрч гурван жилийн өмнөх үетэй харьцуулахад гурав дахин нэмэгдсэн бол зээлдэгчдийн тоо энэ хугацаанд 40 орчим хувиар нэмэгдэж өдгөө 190.000-д хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хямрал, үнэ ханшийн өсөлтөөс болж тэтгэврийн зээл авах зээлдэгчдийн тоо мөнгөн дүнгийн хэмжээ эрс нэмэгджээ. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч буй ахмад настны тоо 220 мянга байдаг гэж үзвэл үндсэндээ 90 хувь нь тэтгэврийн зээлтэй байна. Тэд арилжааны банкуудаас тэтгэврийн зээлийг ахмадуудад сарын 1.5 хувь буюу жилийн 18 хувийн хүүтэйгээр зээлж байна. Өөрөөр хэлбэл, тэтгэврийн зээлтэй ахмадууд дээрх мөнгөн дүнгээс тооцож үзвэл сардаа нийт 5.3 тэрбум төгрөгийн хүү төлж байгаа бөгөөд нэг ахмад дунджаар 28 мянган төгрөг оногдож байгаа тооцоо гарч байна. Тэтгэврээс өөр орлогогүй ахмад буурлууд маань өмнө нь тэтгэврээс тэтгэврийн хооронд амьдрал, ахуйгаа залгуулж байсан бол өнөөдөр авсан тэтгэврээ тэтгэврийн зээл, зээлийн хүүнд өгөөд ч хүрэлцэхгүй хүнд байдалд амьдарч байна.

Нөхцөл байдал ийм байхад эрх баригчид юу хийсэн бэ. Ахмадуудаа энэ хүнд байдлаас гаргахын тулд ямар бодлого хэрэгжүүлсэн бэ гэж асуувал хариулах хүн олдохгүй. Угаасаа АН ахмадуудад чиглэсэн ямар ч бодлого хэрэгжүүлээгүй, тэднийг "хүний тооноос" хассан. АН нэгэнт ахмадууддаа анхаарал хандуулахгүй гэдгийг өнгөрсөн дөрвөн жил та бид хангалттай харлаа. Намууд мөрийн хөтөлбөрөө дэвшүүлсэн, засгийн эрхэнд гарвал нийгмийн үе давхаргуудад чиглэсэн ямар бодлого хэрэгжүүлэхээ ч нээлттэй зарласан. Тэгвэл улс төрийн ууган хүчин ахмадууддаа хэрхэн анхаарал хандуулах вэ. Юуны өмнө Монгол Ардын Нам улс орондоо хийсэн бүтээснээ үнэлүүлж, амар амгалан амьдрах орчинг илүү сайжруулна гэжээ. Түүнчлэн шударга халамжийн системийг тогтоож, ахмадуудыг тэвгэврийн зээлийн өрөнд оруулж байгаа бодлогыг өөрчилж, тэтгэврийн зээлийн хүүг бууруулахаар мөрийн хөтөлбөрөө тусгасан байна. Мэдээж дээр дурдсанчлан ахмадуудад тулгамдсан асуудал бол яах аргагүй тэтгэврийн зээл, түүний хүү. Харин энэ бүхний гарцыг Ардын нам эртнээс олж харсан бөгөөд АН-ынханд санал болгож, ажил хэрэг болгох гээд бараагүй. Тэгвэл иргэд андуурсан сонголтоо засч мандуулбал хийж чадаагүй бүхнээ хийхээрзорьжбайгааньэнэаж.Түүнчлэн ахмадуудын мэдлэг туршлагыг залуу үеийнхэнд өвлүүлэх зорилгоор "ахмад зөвлөх" ажиллуулж, "Ач санах" хуулийн төслийг ч хэрэгжүүлнэ гэжээ. Энэ бүхэн бол сонгуульд зориулж гаргасан шинэ ажил биш гэдгийг энд сануулах нь зүйтэй. Ардын намынхан дээрх хуулийн төслүүдийг хэдийнэ тооцоо судалгааг нь хийгээд бэлэн болгосон төдийгүй Засгийн газарт өргөн барьчихаад байгаа.

Харин АН-ынхан л сөрөг хүчнээс оруулж ирсэн хууль гэх шалтгаанаар ширээнийхээ мухарт шидчихээд байгаа болохоос биш. Ахмад настанд зориулсан эмнэлгийн үйлчилгээ, асаргаа сувилгааг өргөжүүлж, үр ач, эх орноороо бахархан өндөр насандаа авах ёстой бүхий л хүндлэл, ачлалыг хүртэнэ гэжээ. Ийнхүү ахмад, залуу, хойч үеийн гурван үеийн хэлхээн дээр тогтдог Ардын нам ирэх жилүүдэд ахмадуудаа асарч тэтгэх бодлогыг мөрийн хөтөлбөртөө тусгасан байна. Харин тэдэнд энэ мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломж олгох эсэх нь иргэн таны сонголтоос шууд хамаарна. Алдсан цаг хугаа, андуурсан сонголтоо мандуулах цаг нэгэнт иржээ.

# УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Н.ПУНЦАГБОЛД

*УИХ-ын ээлжит сонгууль болоход хэдхэн хоног үлдээд байна. Энэ өдрүүдэд нэр дэвшигчдийн сурталчилгаа хүчээ авч, тэр хэрээрээ янз бүрийн асуудал үүсэх болсон. Тэгвэл сонгуулийн эргэн тойрон дахь асуудлаар Сонгуулийн Ерөнхий хорооны Хууль эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэтэй ярилцлаа.*



# Д.Бат-Эрдэнэ:

## НЭР ДЭВШИГЧИД ХУУЛЬ ЗӨРЧСӨН АСУУДЛЫГ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ШАЛГАЖ, ШҮҮХ ТОГТООНО

**-Сонгууль болоход тав, зургаахан хоногийн хугацаа үлдээд байгаа энэ өдрүүдэд нэр дэвшигчид сурталчилгаагаа ид хийж байна. Тэгвэл ойрын өдрүүдэд СЕХ-нд хэр их гомдол ирж байгаа вэ?**

-СЕХ нэр дэвшигчдийн хууль зөрчсөн асуудлыг хянаж, шийдвэрлэх байгууллага биш. Нэр дэвшигчидтэй холбоотой санал гомдлыг цагдаа, шүүхийн байгууллага л хянаж, шийдвэрлэх үүрэгтэй. Хэрвээ цагдаад ямар нэгэн гомдол ирээд, түүнийг шалгаад, шүүхээр буруутай нь тогтоогдвол дараа дараачийн арга хэмжээг бид авах ёстой. Бидний хувьд цагдаагийн байгууллагатай тодорхой хэмжээнд хамтарч ажиллаж, мэдээ мэдээлэл авч байгаа. Хамгийн сүүлд авсан мэдээллээр 700 орчим гомдол санал ирсэн гэсэн. Харин СЕХ-ны хувьд сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой гомдол саналыг хүлээн авч, шийдвэрлэнэ. Энэ талаар гомдол цөөнгүй ирсэн. Гэхдээ зарим хүмүүс сонгуулийн хуулиа буруу ойлгосноос болж гаргасан гомдлууд цөөнгүй байгаа.

**-Саналын хуудсыг хэвлээд, бэлэн болгосон байгаа юу?**

-УИХ-ын сонгуулийн саналын хуудсыг хэвлээд, аймаг, сум, орон нутаг руу хүргүүлчихсэн байгаа. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээсболоодсонгуультай холбоотой бүхэн бага зэрэг хойшилсон шүү дээ. Бид хэдийгээр богино хугацаанд саналын хуудсыг хэвлэсэн ч ямар ч байсан цагтаа амжсан.

**-УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн Н.Бүргэдаа нэр дэвшигчийн жагсаалтаас хасагдсан. Саналын хуудас хэвлэгдсэний дараа түүнийг нэрдэвшигчийнжагсаалтаас хассан учраас сонгогчдыг мэдээ мэдээллээр хангах ёстой байх?**

-МАХН-аас УИХ-ын 11 дүгээр тойрогт нэр дэвшсэн Н.Бүргэдааг нэр дэвшигчийн жагсаалтаас хассан. Түүнийг УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 70.1 дэх заалтыг зөрчсөн гэдгийг шүүх тогтоосон. Тодруулбал, иргэдийн саналыг татах зорилгоор ажилд оруулж өгнө, ажлын байраар хангана гэсэн амлалт өгсөн юм билээ. Нэгэнт хууль хяналтын байгууллагаас шалгаад, шүүхээс буруутайг баталсан. Шүүхийн шийтгэвэр хүчин төгөлдөр болж, нэр дэвшигчийн жагсаалтаас хассан. Сонгуулийн тухай хуульд заасны дагуу зөрчил гаргасан гэдгийг шүүхээс тогтоосон тохиолдолд нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хассаныг нийтэд мэдээлэх ёстой байдаг. СЕХ-ны 2016 оны зургадугаар сарын 21-ний өдрийн 177 дугаар тогтоолоор нэр дэвшигч Н.Бүргэдааг нэрийн жагсаалтаас хасч, нийтэд мэдээлсэн байгаа. Саналын хуудас хэвлэгдэж дууссаны дараа энэ хүнийг нэрийн жагсаалтаас хассан. Тэгэхээр Сонгуулийн тухай хуулийн 131 дүгээр зүйл дээр үүсэх үр дагаварын тухай нарийн заасан байгаа. Саналын хуудас хэвлэгдсэний дараа нэрийн жагсаалтаас хасагдах юм бол тухайн нэр дэвшигчид өгсөн саналыг санал хураалтад тооцохгүйгээр дүнг гаргах ёстой гэж заасан.

**-Зарим хүмүүс мэдээлэл муу авснаас болоод Н.Бүргэдааг дугуйлах тохиолдол гарч болох юм. Тэгвэл саналын хуудас хүчингүй болно шүү дээ. Тэгэхээр мэдээллийг маш сайн түгээх ёстой юм байна?**

-Сонгуулийн Ерөнхий хорооноос нийтэд мэдээлнэ гэж хуульчилсан чинь энэ үр дагаварыг арилгахад чиглэсэн зүйл. Дээрээс нь аймгийн сонгуулийн хороо сонгогчдоо "Саналын хуудсан дээр энэ бичигдсэн байгаа. Гэвч энэ хүн шүүхийн ийм шийдвэрээр хасагдсан. Нэрийн жагсаалтаас хасагдсан нэр дэвшигчийн төлөө саналаа өгвөл таны санал хүчингүй болно шүү" хэмээн нийтэд мэдээлэл өгөх ёстой.

> ...Юуны өмнө нэг зүйлийг хэлэхэд, шилжүүлэг хийлгэх нь тухайн сонгогчийн эрх. Харин энэ асуудал дээр нэг зүйлийг хянаж үзэж байгаа юм. Сонгогчийг бөөнөөр нь шилжүүлж байгаагийн цаана санал татах зорилготой хууль бус үйл ажиллагаа явагдаад байгаа юм биш үү гэсэн хардлага байна. Нэгдүгээрт, энэ асуудлыг шалгаж тогтоох ёстой. Тогтоодог байгууллага нь СЕХ биш. Гэхдээ СЕХ энэ асуудалд анхаарал тавихгүй, зүгээр хараад суугаад байна гэсэн юм байхгүй. СЕХ-ноос Иргэний бүртгэлийн байгууллага руу албан бичиг явуулсан байгаа...

Энэ ажлаа ч одоо хийгээд явж байгаа.

**-Зарим хүмүүсийг нэр дэвшигчийн жагсаалтаас хасах гэж байгаа тухай мэдээлэл гарч эхэлсэн. Энэ талаар тодорхой мэдээлэл өгөх боломжтой юу?**

-Мэдээлэл гарч байна гэдэг тогтоочихсон гэсэн үг биш шүү дээ. СЕХ шүүхийн шийдвэрийг үндэслэх ёстой. Мөн тэр шүүхийн шийдвэр нь хуулийн хүрээнд хүчин төгөлдөр болсон байна уу гэдгийг харна. Тийм мэдээлэл байгааг үгүйсгэх аргагүй. Гэхдээ бүх зүйлийг шалгах ёстой газар нь шалгаад, хуулийн байгууллага хуулийнхаа хүрээнд ажиллах ёстой гэдгийг би хэлсэн. Гэхдээ сурталчилгаатай холбоотой гомдол гарч байна гэдэг чинь цаанаа нэр дэвшигчийн нэрийн жагсаалтаас хасах үндэслэл байна гэдгийг хэлээд байгаа юм. Гэхдээ тийм гомдлыг хуулийн байгууллага юуны өмнө шалгах ёстой. Цаашлаад шүүхээр тогтоогдох ёстой юм. Түүний дараа СЕХ асуудлаа шийдээд явна.

**-"Царцааны нүүдэл" гээд яриад байна. Олон иргэнийг Улаанбаатар хотоос аймгууд руу шилжүүлж байгаа асуудал. Энэ тал дээр СЕХ тодорхой хэмжээнд анхаарал тавьж ажиллаж байгаа байх?**

-Юуны өмнө нэг зүйлийг хэлэхэд, шилжүүлэг хийлгэх нь тухайн сонгогчийн эрх. Харин энэ асуудал дээр нэг зүйлийг хянаж үзэж байгаа юм. Сонгогчийг бөөнөөр нь шилжүүлж байгаагийн цаана санал татах зорилготой хууль бус үйл ажиллагаа явагдаад байгаа юм биш үү гэсэн хардлага байна. Нэгдүгээрт, энэ асуудлыг шалгаж тогтоох ёстой. Тогтоодог байгууллага нь СЕХ биш. Гэхдээ СЕХ энэ асуудалд анхаарал тавихгүй, зүгээр хараад суугаад байна гэсэн юм байхгүй. СЕХ-ноос Иргэний бүртгэлийн байгууллага руу албан бичиг явуулсан байгаа. Сонгуулийн тухай хууль, Улсын бүртгэл статистикийн ерөнхий газрын даргын баталсан сонгогчийн шилжилттэй холбоотой журмаар бол ямар нэгэн итгэмжлэлээр сонгогчийн шилжилтийг хийнэ гэсэн зохицуулалт байхгүй. Харин бодит амьдрал дээр гэр бүлийнх нь нэг хүн ирэх боломжгүй тохиолдолд хэн нэгэн нь тухайн хүнээтөлөөлөөд,итгэмжлэлийг нь өгөөд, шилжилтээ хийлгэх боломжтой. Гэвч үүнийг дагаад нэг хүн нэлээд олон хүнийг итгэмжлэлээр төлөөлөөд сонгогчийн шилжилтийг хийлгээд байгаа юм. Өөрөөр хэлбэл, 40, 50 хүн нэг л хүнд итгэмжлэл олгочихсон. Өнөөх нь бүгдийнх нь шилжилтийг хийлгэх гээд байдаг. Нэгэнт хуулиаритгэмжлэлээртөлөөлж сонгогчийн шилжилтийг хийнэ гэдгийг зөвшөөрөөгүй учраас нэг хүн олон хүнийг итгэмжлэлээр төлөөлж байгаа тохиолдолд шилжүүлэг хийх боломжгүй гэдгийг Улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлсэн.

**-Сурталчилгааны самбартай холбоотой янз бүрийн санал гомдол бас гараад байгаа. Зарим нэр дэвшигч том самбар ашиглаад байгаа талаар яригдаж л бйана. Энэ тал дээр тодорхой тайлбар хийгээч?**

-Хууль зөрчсөн үйлдэл мөн үү, биш үү гэдгийг СЕХ тогтоохгүй гэдгийг би дахиад хэлье. Сонгуулийн тухай хуульд юу гэж заасан байдаг вэ гэхээр, бизнесийн зориулалтаар байнга ашигладаг сурталчилгааны самбарыг сонгуулийн сурталчилгаанд ямар нэг байдлаар ашиглахгүй гэж заасан байгаа. Тэр санал, гомдол дагуулаад байгаа самбар нь бизнесийн зориулалтаар байнга ашиглагдаж байсан юм уу гэдгийг цагдаагийн байгууллага шалгаад, тогтооно гэсэн үг.

**-Сонгууль болоход хэдхэн хоног үлдээд байна. Гэтэл сонгууль өгөхгүй гэх иргэд цөөнгүй байгаа мэдээлэл гарч байгаа. Тэгвэл СЕХ-ноос иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх тал дээр ямар ажил хийж байна вэ?**

-Нэгдүгээрт, сонгогчдыг мэдээллээр хангах тал дээр нэлээд ажил зохион байгуулж байна. Мэдээллээр хангах бол сонгогчдыг сонгуульд идэвхтэй оролцуулахад хамгийн их үр нөлөөтэй ажил. Тийм болохоор СЕХ –ноос http://songogch.songuuli.gov.mn веб сайт ажиллуулж байгаа. Тэр сайтаараа дамжуулж 76 тойрогт нэр дэвшч байгаа нэр дэвшигчдийн мэдээллийг хүргэж байна. Мөн дээрээс нь санал авах байрны байршлуулаад байгаа. Тухайн сонгогч өөрийнхөө амьдарч байгаа хэсгийнхээ сонгогч мөн үү гэдгийг ч мэдэх боломжтой. Сонгуультай холбоотой зохион байгуулалтын бүхий л шаардагдах мэдээллийг энэ сайт дээр байршуулсан. Дээрээс нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж иргэдийг сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалсан сурталчилгаануудыг явуулж байна. Дээрээс нь иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ТББ-тай ч хамтарч ажиллаж, сонгогчдыг сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалах чиглэлийн ажлыг ч хийж байна.

**-Сонгогчид сонгууль өгөхдөө юуг анхаарах талаар мэдээлэл өгөөч?**

-СЕХ-ноос баталсан загварын дагуу саналын хуудсыг хэвлүүлж дууссан байгаа. Саналын хуудас хоёр хэсгээс бүрдэж байгаа. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгох хэсэг. Доод талд нь аймгийн юм уу нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгох хэсэг байж байгаа. Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт ороод, нэг тойрогт нэг мандаттай болсон. Өөрөөр хэлбэл, сонгогчид маань УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг бөглөх хэсэгт зөвхөн нэг л дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг дугуйлна. Нэгээс илүүг дугуйлчихвал саналын хуудас хүчингүй болно. Харин нийслэл болон аймгийн ИТХ-ын сонгуульд өрсөлдөж байгаа нэр дэвшигчийн тухайд бол тухайн тойрогт хэдэн мандат олгогдсон байна тэр тоогоор нь дугуйлж болно. Эсвэл мандатын тооноос дутуу тэмдэглэгээ хийж бас болно шүү дээ. Иргэдийн хурлын сонгуульд гурван мандаттай тойрог байлаа гэж бодъё. Гэтэл тэр тойрогт дэмжихийг хүссэн нэг л нэр дэвшигч байвал түүнийгээ л дугуйлчихаж болно. Өмнө нь энэ тохиолдолд хүчингүй болдог байсан бол одоо тийм биш. Нэг санал чинь тоологдоод л явна. Эсвэл гурван мандаттай байгаа тойрогт гурван хүний нэрийг ч дугуйлж болно гэсэн үг. Магадгүй сонгогчид алдаа гаргаад, илүү тэмдэглэгээ хийчихлээ гэсэн тохиолдолд санал авах байрны ахлах зохион байгуулагчид энэ тухай мэдэгдээд, дахин нэг удаа саналын хуудас авах боломжтой.

**-Хяналтын тооллого хийхээр хуулинд заасан байгаа. Тэгвэл хяналтын тооллого хийхэд оролцох төлөөллийг ямар байдлаар сонгох юм бол. Энэ асуудалд СЕХ оролцоно биз дээ?**

-Сонгуулийн тухай хууль заасны дагуу сум, дүүргийн сонгуулийн хороод нь санал хураалт дууссанаас хойш 24 цагийн дотор техникийн тооллого хийнэ. Саналын хуудасны 50 хүртэлх хувьд нь техникийн тооллого хийх юм. СЕХ-ны 2016 оны зургадугаар сарын 21-ний хуралдаанаар техникийн тооллого хийх тухай журмыг баталсан. Маш нарийн, нарийвчилсан журмыг баталж өгсөн. Журамд заасны дагуу сум, дүүргийн сонгуулийн хороод нь санал хураалт дууссанаас хойш харьяа хэсгүүдээсээ 50 хүртэлх хувийн саналыг сонгоод, тоолно. Яг хэдэн хувьд нь хяналтын тооллого хийхийг сум, дүүргийн сонгуулийн хороо өөрсдөө шийдэх ёстой. Хуулиар олгосон эрх нь энэ. Тэгэхдээ сонгосон хэсгүүд дотроо аль аль дээр нь хяналтын тооллого хийх вэ гэдгээ СЕХ биш нам, эвслийн ажиглагчид өөрсдөө шийднэ. СЕХ үүнд оролцохгүй. Нам, эвслийн ажиглагчид өөрсдөө зөвшилцөж байгаад, сугалааны зарчмаар сонгоод л, хяналтын тооллогоо хийнэ. СЕХ-ноос санал авах байруудын дугаарыг хайрцаганд хийгээд бэлтгэчихнэ. Тэр дундаас сугалах ажиллагааг нам, эвслийн ажиглагчид өөрсдөө хийх юм.

**-Цахим ертөнцөд янз бүрийн сурталчилгаа гарч байгаа. Бусдын нэр хүндэд халдах ч тохиолдол гарч байна гэсэн мэдээллүүд гарч эхэлсэн. Энэ асуудлыг СЕХ хянаж чадаж байна уу?**

-Энэ асуудлыг интернэт орчинд сонгуулийн сурталчилгааг хийх гээд Сонгуулийн тухай хуулинд заагаад өгчихсөн байгаа. Дээрээс нь сонгуулийн сурталчилгаа явуулахдаа бусыг гүтгэх, доромжлохыг хуулиар хориглосон байгаа шүү дээ. Хэрвээ хэн нэгнийг гүтгэж, доромжилвол Сонгуулийн тухай хуулиар зөрчилд тооцогдоно. Зөрчлийг хэн хянаж, шийдвэрлэх вэ гэхээр буцаад цагдаагийн байгууллага орчихно. Ер нь сонгуулийн сурталчилгаа аль ч хэлбэрээр явагдаж байсан ч бусдыг гүтгэж, доромжилсон мэдээлэл байвал цагдаагийн байгууллагад гомдлоо гаргана. Цагдаагийн байгууллага шалгаад, шүүх тогтоох юм. Энэ асуудалд хяналт тавих боломжгүй гэсэн зүйл биш. Бид хүрээ хүрээндээ, үүрэг үүргийнхээ дагуу хянаад л явж байгаа. Хэрвээ нэр нэр дэвшигч нөгөөгөө доромжилж байна гэж үзвэл баримтжуулаад, цагдаагийн байгууллагад гомдлоо гаргах бүрэн боломжтой.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** Улаанбаатар хот Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны 13-20 дугаар гудамжны нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг. Тендер шалгаруулалтын дугаар: ЗАА-ИБХ-16/29

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны 13-20 дугаар гудамжны нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг эрх бүхий тендерт оролцогчдыг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100.000 [нэг зуун мянган] төгрөгөөр худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн хамт 2 436 000 [хоёр сая дөрвөн зуун гучин зургаан мянган] төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн, 10 цаг–аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,**
**Ц.Жигжиджавын гудамж-9, Нийслэлийн засаг захиргааны II байр,**
**Хангарьд ордон, 602 тоот, утас:31-54-29, 31-54-30**

**Төрийн сан банк: 200051008 Захирагчийн ажлын алба УБ хот НААТХэлтэс**

# ДЭЛХИЙ




# ХЯТАДЫН “АРДЧИЛСАН ТОСГОН”-ЫХОН ЖАГСЧ БАЙНА

Б.ДАВААХҮҮ

Хятадын өмнөд хэсгийн Гуандун мужид удирдагчаа шууд сонголтоор сонгодог цор ганц тосгон бий. “Вукан” гэх энэ тосгон 13 мянган хүн амтай бөгөөд нутгийн иргэд 2011 онд газар шороонызоо төлөө авлигад идэгдсэн нутгийн удирдлагуудаа эсэргүүцэн тэмцсэнээр ардчиллын салхийг сэвэлзүүлсэн гэдэг. Тэгвэл шууд сонголтоор сонгогдсон тосгоны захирагч эдүгээ шоронгийн дөрвөн ханаы дунд хоригдож буй тухай “Франц пресс” агентлаг уламжлав. Тэрбээр орон нутгийн засаг захиргааны дээд байгууллагадаа гомдол гаргахаар зэхэж байтал гэнэт л түүнийг хээл хахуулийн хэрэгт сэжиглэн баривчилсан байна. Тиймээс тосгоны захирагчаа суллуулахаар 3500 гаруй хүн эсэргүүцлийн жагсаал зохион байгуулж буй ажээ. Гуандун мужийн “Вукан” тосгон эдүгээгээс дөрвөн жилийн өмнө газар шороонызоо төлөө тэмцэж, тухайн үедээ л дэлхий нийтийн анхаарлыг татаж байсан гэдэг. Орон нутгийн Коммунист намын удирдлагууд иргэдийн газрыг ямар ч нөхөн төлбөргүйгээр “булаан авч”, барилгын компаниудад худалдсан нь эсэргүүцлийн жагсаалыг өдөөсөн байна. 2011 оны есдүгээр сард эхэлсэн эсэргүүцлийн цуглаан өргөжиж, нутгийн удирдлагуудыг суудлаас нь түлхэн унагаасан аж.

Үүний дараа мужийн захирагчийн шийдвэрээр цагдаа нар Вукан тосгоны замыг хааж, 10 хоног бүсэлсэн аж. Хятадын цагдаа нар олон хүнийг барьж хорин, тамлаж амь насыг нь хөнөөсөн боловч тэмцэл оршин суугчдын ялалтаар өндөрлөсөн юм. Тэд нутгийн удирдлагаа өөрсдөө сонгох эрхийг олж авснаар тэмцэл өндөрлөж, “Ардчилсан тосгон” гэх тодотголыг хүртсэн байна. Тэгвэл хэдхэн хоногийн өмнө цагдаагийн байгууллагынхны бүслэлтэд ороод байсан тосгоны захирагч Лин Зулуан орон нутгийн Засгийн газартаа гомдол гаргаж, эсэргүүцлийн жагсаал зохион байгуулахаар төлөвлөснийхөө төлөө ийнхүү баривчлагдаад байна. Энэ удаа ч мөн хууль бус газрын наймааг эсэргүүцэж байжээ. Гэвч, цагдаагийн байгууллага хэвлэлийн хурал хийх үедээ “Тосгоны захирагч тосгонд төсөл хэрэгжүүлэх нэрийдлээр их хэмжээний хахууль авснаа өөрөө илчилсэн” хэмээн мэдэгдсэн байна. Харин үүнийг нь эсэргүүцсэн тосгоны иргэд “цагдаагийн алба хаагчид хүчээр ял тулгасан” гэж эсэргүүцэн 3500 гаруй иргэн захирагчаа суллуулахаар жагсч байгаа гэнэ.

Одоогоор тосгонд цагдаагийнхан өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж байгаа бөгөөд жагсагчид ямар нэг байдлаар эмх замбараагүй байдал үүсгэлгүй тайван жагсч буй ажээ. Хууль хяналтынханд баривчлагдсан Лин Зулуан 2011 оны жагсаалын гол толгойлогч байжээ. Тэрбээр 6000 гаруй хүний дунд явуулсан нууц санал хураалтаар тосгоны даргаар сонгогдсон байв. Хятадад хөдөө тосгодыг хотжуулах төлөвлөгөө эрчимтэй өрнөхийн хэрээр газраа булаалгасан тариаланчид барилгын компаниудын хооронд үймээн дэгдэх болжээ.

## Өнөөдөр британичууд сонголтоо хийнэ

Их Британичууд Европын холбоонд үлдэх, эсвэл гарах гэсэн хоёр хариултын нэгийг өнөөдөр сонгоно. Ийм чухал санал асуулгын өмнө аль аль байр суурийг дэмжсэн улс төрийн намуудын мэтгэлцээн ид идэвхжиж байна. Хоног хугацаа тулсан яг энэ үед британичууд Европын холбоонд үлдэхийг дэмжигч болон гарахыг дэмжигч гэсэн хоёр хэсэгт хуваагдаад байгаа юм. Их Британийн ерөнхий сайд Дэвид Камерон өнгөрсөн онд болсон парламентын сонгуульд ялвал Европын холбооноос гарах эсэхээр бүх нийтийн санал асуулга явуулах амлалт өгчээ. Түүний ингэх болсон шалтгаан нь Консерватив болон Тусгаар тогтнолын намын эрх баригчид Европын холбооноос гарах эсэх санал асуулга явуулахыг шаардсантай холбоотой. Их Британи өмнө нь 1975 онд Европын холбоонд үлдэх сонголт хийж байжээ. Үүнээс хойш Их Британид маш их өөрчлөлт гарсан бөгөөд иргэд сонголт хийх цаг ирсэн гэж тэд үзсэн аж. Тэгвэл тус сонгуульд Дэвид Камероны тэргүүлэх Консерватив нам ялж, Ерөнхий сайд бүх нийтийн санал асуулгаас өмнө Их Британийн Европын холбоон дахь гишүүний статусыг өөрчлөхийг хичээсэн. Тэрбээр энэ оны эхний хоёр сарын турш Европын холбооны лидерүүдтэй хэлэлцээрийн ширээний ард сууж, гэрээ байгуулсан юм. Түүний хэлснээр Хэрэв Их Британи Европын холбоонд үлдвэл гишүүнчлэлийн давуу эрхийг зөвшөөрсөн гэрээ хэрэгжиж эхлэх юм. Харин гарах сонголтыг хийвэл эдийн засаг нь хэтдээ алдагдал хүлээх эрсдэлтэйг мэргэжилтнүүд сануулж байна.

## Инстаграмм хэрэглэгчдийн тоо хагас саяд хүрчээ




Өөрийн хийгээд өөрт таалагдсан гэрэл зургаа бусаддаа хуваалцах үйлчилгээ хэмээн маш товчоор тайлбарлаж болох Инстаграмм сүлжээний хэрэглэгчдийн тоо хагас саяд хүрчээ. Энэ талаар фэйсбүүк компанийн удирдлагууд мэдэгдсэн байна. Жил ирэх тусам хэрэглэгчдийнх нь тоо нэмэгдсээр байгаа Инстаграммын хэрэглэгчдийн тоо өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 100 саяар нэмэгдсэн байгаа юм. Фэйсбүүк компанийн албан ёсны блогт “Бид өнөөдөр инстаграмм хуудсыг хэрэглэгчдийн тоо нэмэгдэн хагас саяыг давсан туйлын баярт мэдээг хуваалцаж байна. Харин тэдний 300 сая нь өдөр тутамдаа тус сүлжээг ашиглаж байна.

Түүнчлэн бидний харилцаа холбоо улам дэлхий дахинаа өргөжин тархаж, нийт хэрэглэгчдийн 80 гаруй хувь нь гадаад орны хэрэглэгчид байгаа юм” гэсэн байв. Фэйсбүүк компани 2012 онд инстаграмм хуудсыг худалдан авч байжээ. Түүнээс хойш эдүгээ инстаграмм сүлжээ дэлхийн 1.6 сая хүнийг өөртөө нэгтгэсэн фэйсбүүк сүлжээний хэмжээнд хүртлээ өргөжжээ. Мөн зар сурталчилгаанаас олох ашиг нь дэлхий даяар 1.53 тэрбум хүрч, өмнөхөөсөө 144 хувиар өсчээ.

# САНАЛЫН УРИЛГА

Ашигт малтмалын газар нь Ашигт малтмалын тухай хуулийн 19.12, 20.1, 24.2, 26.9, 49.7, 60.9-д заалт, Засгийн газрын 2014 оны 239, 2015 оны 511 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн дараах талбайнуудад ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөл авах сонгон шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгжүүдийг санал ирүүлэхийг урьж байна. **Үүнд:**

1. Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутаг 5467.49 га бүхий Бурам уул нэртэй талбайд

*Талбайн солбицлууд*

| Д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | град | мин | сек | град | мин | сек |
| 1 | 90 | 12 | 45.36 | 49 | 11 | 15.01 |
| 2 | 90 | 11 | 30.43 | 49 | 11 | 15.01 |
| 3 | 90 | 11 | 30.43 | 49 | 12 | 15.44 |
| 4 | 90 | 9 | 45.19 | 49 | 12 | 15.44 |
| 5 | 90 | 9 | 45.19 | 49 | 10 | 44.69 |
| 6 | 90 | 11 | 30.43 | 49 | 10 | 44.69 |
| 7 | 90 | 11 | 30.43 | 49 | 10 | 59.85 |
| 8 | 90 | 12 | 45.36 | 49 | 10 | 59.85 |
| 9 | 90 | 12 | 45.36 | 49 | 9 | 15.48 |
| 10 | 90 | 7 | 0.4 | 49 | 9 | 15.48 |
| 11 | 90 | 7 | 0.4 | 49 | 13 | 59.81 |
| 12 | 90 | 12 | 45.36 | 49 | 13 | 59.81 |

Босго үнэ: 10 384 000 төгрөг
Талбайн код: СШ 10-1

2. Увс аймгийн Малчин сумын нутаг 256.3 га бүхий Сөрт нэртэй талбайд

*Талбайн солбицлууд*

| Д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | град | мин | сек | град | мин | сек |
| 1 | 93 | 6 | 44.99 | 49 | 38 | 0.54 |
| 2 | 93 | 6 | 44.99 | 49 | 37 | 44.72 |
| 3 | 93 | 7 | 15.32 | 49 | 37 | 44.72 |
| 4 | 93 | 7 | 15.32 | 49 | 37 | 30.44 |
| 5 | 93 | 6 | 35.93 | 49 | 37 | 30.44 |
| 6 | 93 | 6 | 35.93 | 49 | 37 | 15.28 |
| 7 | 93 | 5 | 45.23 | 49 | 37 | 15.28 |
| 8 | 93 | 5 | 45.23 | 49 | 37 | 0.12 |
| 9 | 93 | 4 | 59.97 | 49 | 37 | 0.12 |
| 10 | 93 | 4 | 59.97 | 49 | 37 | 15.28 |
| 11 | 93 | 5 | 15.13 | 49 | 37 | 15.28 |
| 12 | 93 | 5 | 15.13 | 49 | 38 | 0.54 |
| 13 | 93 | 5 | 30.07 | 49 | 38 | 0.54 |
| 14 | 93 | 5 | 30.07 | 49 | 37 | 30.44 |
| 15 | 93 | 6 | 0.39 | 49 | 37 | 30.44 |
| 16 | 93 | 6 | 0.39 | 49 | 38 | 0.54 |

Босго үнэ: 576 000 төгрөг
Талбайн код: СШ 10-2

3. Увс аймгийн Малчин сумын нутаг 558.68 га бүхий Ул уул нэртэй талбайд

*Талбайн солбицлууд*

| Д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | град | мин | сек | град | мин | сек |
| 1 | 93 | 3 | 29.87 | 49 | 39 | 15.47 |
| 2 | 93 | 3 | 29.87 | 49 | 39 | 0.31 |
| 3 | 93 | 3 | 45.03 | 49 | 39 | 0.31 |
| 4 | 93 | 3 | 45.03 | 49 | 38 | 30.21 |
| 5 | 93 | 4 | 0.19 | 49 | 38 | 30.21 |
| 6 | 93 | 4 | 0.19 | 49 | 38 | 15.05 |
| 7 | 93 | 3 | 45.03 | 49 | 38 | 15.05 |
| 8 | 93 | 3 | 45.03 | 49 | 37 | 30.44 |
| 9 | 93 | 4 | 0.19 | 49 | 37 | 30.44 |
| 10 | 93 | 4 | 0.19 | 49 | 37 | 15.28 |
| 11 | 93 | 3 | 45.03 | 49 | 37 | 15.28 |
| 12 | 93 | 3 | 45.03 | 49 | 37 | 0.12 |
| 13 | 93 | 3 | 29.87 | 49 | 37 | 0.12 |
| 14 | 93 | 3 | 29.87 | 49 | 37 | 44.72 |
| 15 | 93 | 3 | 14.71 | 49 | 37 | 44.72 |
| 16 | 93 | 3 | 14.71 | 49 | 38 | 0.54 |
| 17 | 93 | 2 | 45.26 | 49 | 38 | 0.54 |
| 18 | 93 | 2 | 45.26 | 49 | 37 | 44.72 |
| 19 | 93 | 2 | 30.1 | 49 | 37 | 44.72 |
| 20 | 93 | 2 | 30.1 | 49 | 37 | 30.44 |
| 21 | 93 | 1 | 45.5 | 49 | 37 | 30.44 |
| 22 | 93 | 1 | 45.5 | 49 | 37 | 44.72 |
| 23 | 93 | 1 | 30.34 | 49 | 37 | 44.72 |
| 24 | 93 | 1 | 30.34 | 49 | 38 | 0.54 |
| 25 | 93 | 1 | 45.5 | 49 | 38 | 0.54 |
| 26 | 93 | 1 | 45.5 | 49 | 38 | 15.05 |
| 27 | 93 | 2 | 0 | 49 | 38 | 15.05 |
| 28 | 93 | 2 | 0 | 49 | 38 | 30.21 |
| 29 | 93 | 2 | 30.1 | 49 | 38 | 30.21 |
| 30 | 93 | 2 | 30.1 | 49 | 38 | 45.15 |
| 31 | 93 | 2 | 45.26 | 49 | 38 | 45.15 |
| 32 | 93 | 2 | 45.26 | 49 | 39 | 0.31 |
| 33 | 93 | 3 | 14.71 | 49 | 39 | 0.31 |
| 34 | 93 | 3 | 14.71 | 49 | 39 | 15.47 |

Босго үнэ 1 254 000 төгрөг
Талбайн код: СШ 10-3

4.Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг 1173.21 га бүхий Баян уул нэртэй талбайд

*Талбайн солбицлууд*

| Д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | град | мин | сек | град | мин | сек |
| 1 | 104 | 53 | 15.04 | 46 | 38 | 45.15 |
| 2 | 104 | 53 | 15.04 | 46 | 40 | 44.68 |
| 3 | 104 | 55 | 44.68 | 46 | 40 | 44.68 |
| 4 | 104 | 55 | 44.68 | 46 | 38 | 45.15 |

Босго үнэ 423 000 төгрөг
Талбайн код: СШ 10-5

6. Увс аймгийн Наранбулаг, Өлгий сумдын нутаг 2300.07 га бүхий Хар үзүүр нэртэй талбайд

*Талбайн солбицлууд*

| Д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | град | мин | сек | град | мин | сек |
| 1 | 92 | 7 | 0.19 | 49 | 20 | 15.09 |
| 2 | 92 | 7 | 0.19 | 49 | 21 | 0.36 |
| 3 | 92 | 9 | 0.38 | 49 | 21 | 0.36 |
| 4 | 92 | 9 | 0.38 | 49 | 24 | 0.31 |
| 5 | 92 | 11 | 30.23 | 49 | 24 | 0.31 |
| 6 | 92 | 11 | 30.23 | 49 | 20 | 45.19 |
| 7 | 92 | 10 | 44.75 | 49 | 20 | 45.19 |
| 8 | 92 | 10 | 44.75 | 49 | 20 | 30.03 |
| 9 | 92 | 9 | 44.99 | 49 | 20 | 30.03 |
| 10 | 92 | 9 | 44.99 | 49 | 20 | 15.09 |

Босго үнэ 5 162 000 төгрөг
Талбайн код: СШ 10-6

7. Увс аймгийн Наранбулаг, Өлгий сумдын нутаг 672.56 га бүхий Хөх толгой нэртэй талбайд

*Талбайн солбицлууд*

| Д/д | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | град | мин | сек | град | мин | сек |
| 1 | 92 | 8 | 59.24 | 49 | 24 | 1.74 |
| 2 | 92 | 8 | 59.23 | 49 | 21 | 1.75 |
| 3 | 92 | 7 | 59.23 | 49 | 21 | 1.75 |
| 4 | 92 | 7 | 59.24 | 49 | 24 | 1.74 |

Босго үнэ 1 510 000 төгрөг
Талбайн код: СШ 10-7

1. Сонгон шалгаруулалт зарлах талбайн босго үнэ болон бусад мэдээллийг Ашигт малтмалын газрын цахим хуудсанаас (www.mram.gov.mn) авна уу. Мөн Ашигт малтмалын газраас авч болно.

2. Үйлчилгээний хураамж болох 250.000 төгрөг төлсөн баримтыг үндэслэн Сонгон шалгаруулалтын талбайн товч мэдээллийг авч болно.

3. Сонгон шалгаруулалтад оролцох саналыг 2016 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 17 цаг хүртэлх хугацаанд Ашигт малтмалын газрын 207 тоот өрөөнд Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн даргад оролцогч аж ахуй нэгж, байгууллагын захирал, дарга эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч биечлэн хүлээлгэн өгнө.

4. Сонгон шалгаруулалтад оролцох саналыг сонгон шалгаруулалтанд оролцогч аж ахуйн нэгжийн захирал эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байлцуулан 2015 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 9 цаг 00 минутад Ашигт малтмалын газрын хурлын танхимд нээнэ. Аж ахуйн нэгжийн захирал эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тогтоосон хугацаанд ирээгүй бол саналыг задлахгүйгээр хүчингүйд тооцож буцаан хүлээлгэн өгнө.

5. Ирүүлсэн саналыг АМГ-ын даргын тушаалаар батлагдсан коммисс нь Уул уурхайн сайдын 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 10 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”, уг журамд Уул уурхайн сайдын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 126 дугаар тушаалаар орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу үнэлнэ.

6. Сонгон шалгаруулалтад оролцох санал ирүүлэх хаяг:

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-3, Ашигт малтмалын газар 207 тоот өрөө,

Сонгон шалгаруулалт явуулах комиссын нарийн бичгийн дарга, утас 263710

7. Саналд дараах бичиг баримтыг хавсарган ирүүлнэ.

**Үүнд:**

- Сонгон шалгаруултад оролцох санал /маягтын дагуу/
- Санал гаргагчийн албан ёсны тодорхойлолт (маягт К-4)
- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (нотариатаар баталгаажуулсан)
- Монгол Улсад татвар төлөгч болох тухай нотолгоо (харьяа татварын албанаас)
- Сонгон шалгаруулалтын босго үнийг Монгол Банкинд бүртгэлтэй арилжааны банкинд хугацаатай /Сонгон шалгаруулалтын саналыг нээсэн өдрөөс хойш ажлын 15 хоног/ байршуулсан баталгаа
- Сонгон шалгаруулалтанд оролцох битүүмжлэгдсэн үнийн санал (босго үнэ + санал үнэ)
- Тухайн талбайд гүйцэтгэх хайгуул болон ашиглалтын ажлын төрөл хэмжээ, хугацаа, өртөг болон байгаль хамгаалахад зарцуулах зардлыг тоймлон тусгасан төсөл, төсвийн санал
- Хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт (баримтыг наториатаар гэрчлүүлсэн байна)
- Мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал. (баримтыг наториатаар гэрчлүүлсэн байна)
- Хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг явуулах, дэвшилтэт арга, аргачлал, технологийн шийдэл;
- Ашигт малтматын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зураг.
- Үйлчилгээний хураамж 250 000 төгрөгийг Төрийн сан – 900018003 тоот дансанд төлсөн баримт (төлбөрийн баримтын эх хувь)

**АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР**

ШУУРХАЙ МЭДЭЭ

## Авто машингүй өдрийг дахин зохион байгуулна

Автозамын ачааллыг үе шаттайгаар бууруулах, хүрээлэн буй орчин болоод нийгэмд автомашины хэрэглээнээс үүдэн учирч буй сөрөг нөлөөг багасгахад олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор жил бүр “Авто машингүй өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг болсон билээ. Энэ жилийн хувьд зургадугаар сарын 4-ний өдрийг Автомашингүй өдөр болгосон. Тэгвэл автомашингүй өдрөөр нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлын хэмжээг тодорхойлох зорилгоор Нийслэлийн Агаарын чанарын албанаас хэд хэдэн байршилд хэмжилт хийсэн байна.Тодруулбал, зам хаасан цэгүүдэд буюу Ялалтын талбай, МУИС, Зүүн дөрвөн зам орчим, Баруун дөрвөн зам орчим нийт дөрвөн цэг дээр орчны агаарын бохирдлын хэмжээг тогтоож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнт үетэй харьцуулсан хэмжилтийг хийжээ. Ингэхэд NO2-азотын давхар ислийн агууламж автомашинтай өдрийн хэмжилтээр бүх цэгүүд дээр авто машингүй өдрийн утгаас хоёр дахин давсан үзүүлэлттэй байжээ. Энэ нь тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас уг хий замын дагуух орчинд ихээхэн хэмжээгээр хаягддаг болохыг харуулжээ. Тиймээс энэ зун автомашингүй өдрийг нийслэлд дахин хийхээр төлөвлөж байгаа ажээ.

# БАРИЛГЫН ОСЛЫН УЛМААС ЗУРГААН ХҮН БЭРТЭЖ, НЭГ ХҮН АМИА АЛДСАН

*Н.БАТЗАЯА*

*Барилгын ажил эхлэхтэй зэрэгцээд барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, осол, гэмтлийн асуудал гарч ирдэг. Тиймээс энэ талаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын хэлтсийн улсын ахлах байцаагч М.Ууганбаяраас зарим зүйлийг тодруулаа.*

**-Барилгын ажил эхлээд сар гаруйн хугацаа өнгөрсөн байна. Барилгын компаниудад шалгалт хийгдэж байгаа юу?**

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд ажил олгогч, ажилтан хоёрын эрх, үүргийг тусгаж өгсөн. Ажилтан ямар үүрэгтэй, ажил олгогч ямар үүрэгтэй вэ гэдгийг хуульдаа заасан учраас энэ талаар ярих нь илүүц байх гэж бодож байна. Гэхдээ ажилчид ажил олгогч эздийн хангаж өгсөн хувцас, хамгаалах хэрэгслийг өмсөх, өөртөө болон бусдад аюулт эрсдэл учруулахгүй байх үүрэгтэй. Мөн тухайн байгууллагаас гаргасан дотоод дүрэм, журмыг мөрдөж ажиллана гэж заасан байдаг. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга болон Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга 185 тоот удирдамж гаргасан. Удирдамжийн хүрээнд шинээр баригдаж байгаа барилгуудад урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийж байна. Шалгалтыг тавдугаар сарын сүүлээр явуулж эхэлсэн. Урьдчилан сэргийлэх, хяналт, шалгалтууд үргэлжилж байгаа.

**-Энэ жил хичнээн барилгын компани үйл ажиллагаа явуулж байгаа вэ?**

-Нарийн тоог нь мэдэхгүй байна. Гэхдээ нэгдсэн шалгалтын дүнг найм, есдүгээр сард танилцуулна. Тэр шалгалтын дүнгээр нэгдсэн тоо гарна. Ер нь Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд 500 гаруй объект төлөвлөгөөт шалгалтад орохоор тусгагдсан. Төлөвлөгөөт шалгалтад орох 500 объект нь өнгөрсөн жил эрсдэл өндөртэй гарсан юм. Тиймээс энэ жил төлөвлөгөөт шалгалтад оруулж байгаа.

**-Барилгын ажил эхэлснээс хойш осол гарсан уу. Хэчнээн хүн бэртэж гэмтсэн бэ?**

-Манай шуурхай байдлын албанд долоон дуудлага ирсэн. Бид дуудлагын дагуу очиж, шалгалт хийсэн. Одоогийн байдлаар зургаан хүн хүнд хөнгөн бэртэж, нэг хүн амь насаа алдсан байна.

**-Хяналт шалгалтын явцад шинээр баригдсан барилгууд ихэвчлэн ямар зөрчил гаргаж байна вэ?**

-Шинэ баригдаж байгаа барилгуудад шалгалт хийх тухай НИХТ-ийн тэргүүлэгчдийн 77 дугаар тогтоол гарсан. Барилга угсралтын ажил эрхэлж байгаа компаниуд нийтлэг журамд заасан хашаа бариагүй, зураг батлаагүй, талбайн зохион байгуулалтын зураг байхгүй зэрэг зөрчил илэрлээ. Мөн хаалт хамгаалалтгүй, ажилчид нь ажлын хувцасгүй, хамгаалах хэрэгсэл хангагдаагүй зэрэг зөрчлүүд илэрч байгаа.

**-Барилгын компанитай холбоотой иргэдийн гомдол ирж байна уу?**

-Иргэдээс шөнийн цагаар барилгын ажил явуулж байна гэсэн гомдол ирсэн. Сүүлийн үед иргэдийн мэдлэг харьцангуй дээшилсэн нь мэдэгдэж байна. Тухайлбал, манай шуурхай албаны утсанд хаалт, хамгаалалт хийгээгүй барилга үйл ажиллагаа явуулж байна, барилга дээр хамгаалах хэрэгсэлгүй хүн ажиллаж байна гэх мэтчилэн гомдол иргэдээс ирдэг. Тэгэхээр эндээс иргэдийн мэдлэг сайжирч байгааг харж болно.

**-Ажил олгогчид ихэвчлэн ямар зөрчил гаргадаг вэ?**

-Барилгын компаниуд хөрөнгө, санхүү дутмагаас болж барьж байгаа барилгадаа хамгаалах хаалт хийдэггүй. Ажилчиддаа хамгаалах бүс тавьж өгсөн боловч бэхэлгээг нь хийж өгдөггүй. Мөн дотоодын хяналт, шалгалт муу байдаг. Энэ мэтчилэн зөрчлүүд ажил олгогчдын дунд ихэвчлэн гардаг.

**-Барилгын ажилчдын хамгаалах малгай хэр чанартай байдаг юм бэ?**

-Манай улсад барилгын хамгаалах малгай чанарын шаардлага хангасан эсэхийг шалгадаг лаборатори байдаггүй. Ажил олгогчид импортоор орж ирсэн хамгаалах хэрэгслийг худалдаж авдаг. Гэхдээ тухайн бүтээгдэхүүнийхээ дагалдаж ирсэнсертификатыгсайнхарах хэрэгтэй. Хэзээ үйлдвэрлэсэн, чанарын шаардлага хангасан эсэхийг анхаарч авах ёстой.

**-Зөрчил гаргасан компаниудад ямар зөвлөгөө өгч ажиллаж байна вэ?**

-Бид эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийдэг тогтолцоонд шилжээд таван жил болж байна. Мөн эрсдэл багатай үнэлэгдсэн байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ болон зөвлөгөө өгдөг. Барилгын талбайн инженер, ХАБ-ын ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгч ажилладаг.

PHOTO NEWS





Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

*Улсын нэгдүгээр төв эмнэлгийн салбар амбулаторийн нээлт өнөөдөр боллоо. Энэхүү үйл ажиллагаанд Ерөнхий сайд Ч.Сайханбилэг оролцсон юм. Тус амбулатори энэ долоо хоногийн эхний өдрөөс ажиллаж, энэ өдрүүдэд 400 орчим иргэнд үйлчилгээ үзүүлжээ. Нээлтийн үйл ажиллагааны үеэр эмч ажилтнуудыг ард иргэддээ мэргэжлийн өндөр түвшинд үйлчилгээ үзүүлж, шинэ ноу хау, дэвшилтэд технологи нэвтрүүлж, шинэ ололт амжилтаар дүүрэн ажиллана гэдэгт итгэлтэй байгаагаа Ерөнхий сайд илэрхийллээ.*

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Үер усны аюулаас болгоомжил

Цаг уурын байгууллагаас ирүүлсэн мэдээгээр Алтайн нуруунаас эхтэй Булган, Хар бут, Ховд, Хөвсгөлийн уулсаас эхтэй Богд, Завхан, Орхон, Улиастай, Хэнтэйн нуруунаас эхтэй Сэлэнгэ мөрөн, Баянхонгор аймгийн Байдраг, Шаргалжуут гол Өвөрхангай аймгийн Онги голууд үерийн аюултай түвшинд хүрчээ. Энэ сарын 23-ны өдөр төв, зүүн аймгуудын зарим газраар, 24-ний өдөр баруун аймгуудын нутаг, төвийн аймгуудын баруун хэсгээр, 25-ны өдөр баруун болон төвийн аймгуудын зарим газраар бороо орох тул гол, мөрний усны түвшин нэмэгдэх төлөвтэй байна. Тиймээс Онцгой байдлын ерөнхий газраас үер усны аюулаас болгоомжтой байхыг анхааруулаа.

## Ирэх сарын 1-нээс Замын-Үүдийн өртөөнд түр ачаа олгохгүй

УБТЗ-ын дарга Замын-Үүдийн өртөөнд түр ачаа олгохгүй байх тушаал гаргажээ. Уг тушаалын дагуу долдугаар сарын 1-нээс эхэлж Замын-Үүд өртөөнд түр хугацаагаар ачаа олгохгүй юм байна. Иймд тус боомтоор ачаа тээврийн үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд эртнээс зохицуулалт хийх шаардлагатай болсон гэнэ. Тодруулбал, олон улсын тээвэрлэлт ачилтыг зохион байгуулахдаа ирэх долдугаар сарын 1-нээс хойш тээвэрлэсэн ачаа нь Монгол Улсын хилээр нэвтрэх бол тээвэр зуучтайгаа холбогдон зөвлөгөө авч ажиллахыг мэргэжлийн байгууллагаас анхааруулаа.

## ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

- Буднаа овогтой Дулам эмээлтийн 1.7 га газрын 18617308962367 дугаартай гэрчилгээ гээсэн тул хүчингүйд тооцов

## Хөшигтийн хөндий рүү хөнгөн галт тэрэг явна

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүл, Монгол–Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын дарга Л.Пүрэвбаатар нар нийслэл орчмын төмөр замын зорчигч тээврийг хөгжүүлэх, “Аэро-Экспресс” төмөр замыг барьж ашиглах тухай санамж бичигт өчигдөр гарын үсэг зурлаа. Энэхүү санам бичигт гарын үсэг зурснаар, “Аэро-Экспресс” төмөр замыг барьж ашиглах, хотын төвөөр дайран өнгөрөх төмөр замаар тээвэрлэгдэж байгаа ачаа тээврийн хэмжээг багасгах, аюултай ачааны тээвэрлэлтийг зогсоох боломжтой болох юм. Мөн нийслэлийн “Зорчигч үйлчилгээний төв буудал”-ыг шинэчлэн өргөтгөх, Улаанбаатар хотын дундуур өнгөрөх төмөр замыг хос болгон өргөтгөх замаар хотын ойролцоох Налайх, Партизаны суурин газруудыг дэд бүтэцтэй холбож хотын нийтийн тээврийн сүлжээтэй нэгтгэх зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр болжээ. Түүнчлэн санамж бичгийн хүрээнд Хөшигийн хөндийд шинээр ашиглалтад орох Олон Улсын нисэх буудал-Улаанбаатар хотын хооронд хурдан галт тэрэг Рейлбус явж эхэлнэ. Үүний тулд шинэ Рейлбус худалдан авч нийтийн тээврийн шинэ чиглэл бий болгон орчин үеийн шаардлагад нийцсэн тасралтгүй үйлчилгээг үзүүлэх, засвар үйлчилгээний баазыг байгуулах шаардлагатай ажээ. Мөн Улаанбаатар хотын нийтийн тээврийг төмөр замын тээвэртэй уялдуулж авто замын ачааллыг багасган түгжрэлийг бууруулж, Толгойт-Амгалан өртөөдийн хооронд хос төмөр зам тавих, төмөр замын дагуу автобус нийтийн тээврийн зогсоол бүхий платформ байгуулахаар тусгажээ. Ингэснээр Налайх, Эмээлт, Өлзийт, Нисэх орчмиын иргэд Төв аймгийн Хөшгийн хөндийн байрлах олон улсын нисэх онгоцны буудал руу хөнгөн галт тэргээр зорчих боломжтой болох юм. Энэхүү санамж бичгийн хүрээнд талууд Улаанбаатар хотын автозамын тээх нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх, явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан гарцуудыг бий болгох зорилгоор Нийслэлийн “Зорчигч үйлчилгээний төв буудал”-ыг өргөтгөн цогцолбор байгуулж төмөр замын урд хойд талыг холбосон шинэ явган гарц бий болгох юм байна. Барилгын материалын худалдааны үйл ажиллагаа төвлөрсөн 44 дүгээр зам буюу Гурвалжингийн гүүрний орчмын үйл ажиллагааг бүхлээр нь хотын зүүн хэсэгт шилжүүлж, Амгалан өртөөний орчим орших объектуудыг түшиглэн барилгын болон мод модон материалын захыг шинээр бий болгон төвлөрүүлэх аж. Хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх бүтээн байгуулалтыг энэ намраас эхлүүлж эхний үе шатыг 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Бүтээн байгуулалтын ажил 2030 онд дуусах юм байна.

## Монголын уул уурхайн салбарт шинэ технологи нэвтрүүлнэ

Б.НОМИН

Дэлхийд тэргүүлэгч, уул уурхайн салбарт инновацийн хувьсал хийсэн “Женерал Электрик” компанитай “Эрдэнэс Монгол” ХХК харилцан ойлголцлын санамж бичиг өчигдөр байгууллаа. Уг санамж бичгийг байгуулснаараа Монголын байгалийн нөөцийн үнэ цэнэ, хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чухал алхам болж байна. Санамж бичгийн хүрээнд уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн салбаруудад зохистой шийдэл олох зорилготой томоохон төслүүдэд “Эрдэнэс Монгол”, “Женерал Электрик” компаниуд хамтран ажиллахаар болжээ. “Женерал Элекрик” компани нь салбартаа шинэ технологийг нэвтрүүлдгээрээ алдартай. Иймд Монгол Улстай уул уурхайн шинэ технологийг нэвтрүүлэх ажлаар түлхүү хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа тус компанийн Ази, Номхон далайн бүсийг хариуцсан гүйцэтгэх захирал Мухамед Батт санамж бичгийг үзэглэх ёслолын ажиллагааны үеэр илэрхийллээ. Мөн Мухамед Батт “Манай компани нь зөвхөн технологийн шийдэл гаргахаас гадна хүний нөөцийн сургалт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Энэ ч утгаараа Монгол Улсын төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хүний нөөцийн чиглэлээр залуусыг сургаж хөгжүүлэхэд бэлэн байна” хэмээлээ. Тус компани болон “Эрдэнэс Монгол” компани нэн тэргүүнд Оюу толгой гүний уурхайн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлж, үүний дараагаар Таван толгойн төслүүд дээр хамтран ажиллахаар болж байгаа юм байна. Төслийн хүрээнд уул уурхайн инновацийг нэвтрүүлэх боломжийг судлах, шинэ тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, ашиглах төслийг хэрэгжүүлэх аж. Мөн “Эрдэнэс Монгол” компанийн охин компани болон хараат компаниудын чадавхийн сайжруулах, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, төмөр зам, усны дэд бүтцийн эрчим хүч үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэх юм байна.

# ЗАВСАРЛАГА


DELL
ЗӨВХӨН 6-Р САРД
КОМПЬЮТЕР ХУДАЛДАН
АВСАН ХҮН БҮР
9 БЭЛЭГТЭЙ
ЭСВЭЛ
БОНУС КАРТ 5%
урамшуулалтай
Зөвхөн "DELL Center"-т
Хаяг: Компьютер Ландын зүүн талд DELL Center
Холбогдох утас: 9906-9493, 9904-2031